Хавсралт

**Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, 2021 оны жилийн эцсийн байдлаар, Эрүүл мэндийн яам**

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв, 2021 он (сая төгрөг), Эх үүсвэр | 2021 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр | Хариуцах газар, хэлтэс | Үнэлгээ-ний хувь, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **НЭГ. КОВИД-19 ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО** | | | | | | | | |
| 1 | 1.1.2. КОВИД-19 халдварт цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлж, бэлэн байдлыг хангахтай холбоотой төсвийн санхүүжилтийг нэмэгдүүлнэ | 2.Цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авахад зориулсан санхүүжилтийг боломжит хэмжээгээр нэмэгдүүлнэ | 2020-2021 | Улсын төсөв | Хариу арга хэмжээ авах, эмнэлгийн бэлэн байдлыг хангахад шаардлагатай 17 долоо хоног буюу 120 өдөр (4 сар)-ын нөөцийг бүрдүүлсэн байна. | Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, эмнэлгүүдийн бэлэн байдлыг хангах, нөөц бүрдүүлэх, илүү цагийн хөлс, урамшуулал, дэмжлэг олгоход 2021 онд нийт 309.46 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Үүнд:<br>- Коронавируст халдварын цар тахлаас сэргийлэх, хариу арга хэмжээ авах хүрээнд эрүүл мэндийн салбарын бэлэн байдлыг хангах, нөөц бүрдүүлэх зорилгоор хөрөнгө шийдвэрлүүлэх асуудлыг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэн 6 удаагийн шийдвэрээр 66.8 тэрбум төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас шийдвэрлүүлж зарцуулсан.<br>- Засгийн газрын 2021 оны 169 дүгээр тогтоолын дагуу “Эрдэнэс таван толгой” ХХК-аас 13.0 тэрбум төгрөгийн нэмэлт санхүүжилтийг шийдвэрлүүлж вирусын эсрэг эм, урвалж оношлуурын зардалд зарцуулсан.<br>- 2021 оны төсвийн тодотголоор коронавируст халдварын эсрэг хариу арга хэмжээнд шаардлагатай төсвийг тооцож нийт 229.8 тэрбум төгрөгийг | СЭЗГ-СДХ ЭЭХХЗГ<br><br>I-IV улирал | **90.0** |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв, 2021 он (сая төгрөг), Эх үүсвэр | 2021 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр | Хариуцах газар, хэлтэс | Үнэлгээ-ний хувь, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нэмэгдүүлэн батлуулж зарцуулсан. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын 2021 оны 67/А/268, А/387/99 дүгээр хамтарсан тушаалуудыг тус тус баталж, нийт 360.5 тэрбум төгрөгийг зарцуулсан. Эм, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгсэл, ПГУ оношлуурын нөөцийн мэдээг өдөр бүр ЭЭХХЗГ-т мэдээний санд бүртгэж байна. 2021 оны жилийн эцсийн байдлаар төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагуудад оношлуур 29 гаруй хоног, хувийн хамгаалах хэрэгсэл 44-234 хоног, вирусын эсрэг эм 56-827 хоног, антибиотик 65-872 хоног, амилуулах тусламж, үйлчилгээний эм 91-357 хоног, дуслын шингэн болон шинж тэмдгийн эсрэг эм 68-260 хоногийн нөөцтэй байсан. | | |
| 2 | | 4.Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийг улирлын томуугийн вакцинд бүрэн хамруулна | 2020-2021 | 9,200.0 Улсын төсөв, Гадаадын зээл, тусламж | Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийн 80-аас доошгүй хувийг улирлын томуугийн вакцинжуулалтад бүрэн хамруулсан байна. | 2021 оны төсөв дээр нэмж 15 тэрбум төгрөг батлуулж, томуугийн вакцин 300,000 тунг нэмж захиалснаар нийт 360,000 тун вакциныг томуугийн вакцинжуулалтад хэрэглэх бэлтгэл ажлыг хангасан. ЭМЯ-ны худалдан авалтаар 300,000 хүн тун, НҮБ-ын Хүүхдийн сангаар 60,000 хүн тун авсан бөгөөд нийт төсөв 4.6 тэрбум төгрөгийг | НЭМГ- ХӨХ<br>III улирал | **100.0** |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв, 2021 он (сая төгрөг), Эх үүсвэр | 2021 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр | Хариуцах газар, хэлтэс | Үнэлгээ-ний хувь, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зарцуулсан. Төлөвлөгөөний дагуу 2021 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр вакциныг хүлээн авч, Эрүүл мэндийн сайдын 2021 оны "Улирлын томуугийн эсрэг вакцинаар дархлаажуулах тухай" А/565 дугаар тушаал баталсан. Эцэг, эх, асран хамгаалагчийн зөвшөөрлийг үндэслэн 2-11 насны 235,678 хүүхдийг 2021 оны жилийн эцсийн байдлаар улирлын томуугийн вакцинд хамруулсан. Энэ нь нийт хамрагдвал зохих хүүхдийн 98.6 хувийг эзэлж байна. | | |
| 3 | | 5.Халдварт өвчин судлалын үндэсний төв, Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн эмч, ажилчдад олгох цалин, урамшуулал, дэмжлэгийг нэмэгдүүлнэ | 2020-2021 | 24,300.0 Улсын төсөв | Коронавирусийн халдварын голомтод ажилласан эмнэлгийн ажилтнуудад илүү цагийн хөлс, урамшуулал, дэмжлэг олгогдсон байна. | Коронавируст халдварын голомтод ажилласан Халдварт өвчин судлалын үндэсний төвийн эмнэлгийн ажилтнуудын цалин, урамшуулал, дэмжлэгт 8.3 тэрбум төгрөг, Зоонозын өвчин судлалын үндэсний төвд 1.2 тэрбум төгрөгийг 2021 онд тус тус олгосон байна.<br>Мөн Эрүүл мэндийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасны дагуу Олон улсын хөл хориот халдварт өвчний голомтод болон гамшгийн үед дайчилгаагаар ажилласан эрүүл мэндийн ажилтанд олгох нэг удаагийн санхүүгийн дэмжлэгийг ХӨСҮТ-ийн 1,596 (давхардсан тоогоор) албан хаагчдад 7 удаагийн шийдвэрээр 2.8 тэрбум төгрөг, ЗӨСҮТ-ийн 249 (давхардсан тоогоор) албан хаагчдад 3 удаагийн шийдвэрээр 415.4 сая төгрөгийг тус тус | СЭЗГ- СДХ<br>I-IV улирал | **100.0** |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв, 2021 он (сая төгрөг), Эх үүсвэр | 2021 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр | Хариуцах газар, хэлтэс | Үнэлгээ-ний хувь, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | олгосон байна. | | |
| 4 | | 6.Хүн амыг коронавирусийн эсрэг вакцинд хамруулна | 2020 - 2021 | 12,462.6 Улсын төсөв (ЭМДС), Гадаадын зээл, тусламж | Хүн ам коронавирусийн вакцинд хамрагдсан байна. | Монгол Улсын Засгийн газраас коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг 5 төрлийн (АстраЗенека (AZD1222), Пфайзер/БиоНТех BNT162 (Comirnaty), АстраЗенека (COVISHIELD), Спутник-В Гам-КОВИД-Вак, Синофарм CorV (Verocell))-ийн вакцины нийт 8,317,750 хүн/ тунг татан авч, нийт хүн амыг 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн вакцинжуулж байна.<br>Улсын хэмжээнд 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакцины хамралт:<br>1. Зорилтот бүлгийн 1 дүгээр тунгийн хамралт 96.1 хувь, 2 дугаар тунгийн хамралт 91.8 хувь, 3 дугаар тунгийн хамралт 47.9 хувь;<br>2. Нийт хүн амын 1 дүгээр тунгийн хамралт 69.7 хувь, 2 дугаар тун - 66.5 хувь, 3 дугаар тун - 28.2 хувьтай байна.<br>Өссөн дүнгээр 3 дугаар тунд 916,096 хүн хамрагдсан байна. Өссөн дүнгээр 1 дүгээр тунд 6,388 жирэмсэн эмэгтэй, 7,734 хөхүүл эмэгтэй, 12-15 насны 176,251* хүүхэд, 16-17 насны 76,763* хүүхэд хамрагдсан байна.<br>КОВАКС хөтөлбөрөөс 2021 онд ДЭМБ-ын чанар, аюулгүй байдлыг хангасан 1,329,060 тун вакцин буюу нийт хүн амын 20.24%-ийг хамрах тооны | ТЗУГ-ГХАХ, НЭМГ-ХӨХ<br>I улирал | **100.0** |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв, 2021 он (сая төгрөг), Эх үүсвэр | 2021 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр | Хариуцах газар, хэлтэс | Үнэлгээ-ний хувь, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | вакциныг хүлээн авсан ба вакцин хүлээн авахтай холбоотой бүх ажлыг амжилттай гүйцэтгэсэн. КОВАКС механизмын хүрээнд 2021 онд Пфайзер вакцины тарилгад хэрэглэх 0.3 мл хэмжээтэй өөрөө эвдрэх 900,000 ширхэг тариурыг аюулгүй хайрцгийн хамт тус тус хүлээн авсан. | | |
| 5 | | 7.Коронавируст халдвар (КОВИД-19)-тай холбоотой хийгдэх судалгааны ажлын тэргүүлэх чиглэлийг батлуулах, судалгааны ажил болон санхүүжилтийг шийдвэрлүүлж, үр дүнг хүлээн авна. | 2020-2024 | 600.0 Улсын төсөв (Шинжлэх ухаан технологийн сан) | Монголд илэрсэн САРС-КоВ-2 (SARS-CoV-2)-ын омгуудын геномын бүтцийг тодорхойлж, молекул эпидемиологийн онцлогийг тогтоон, онош, тандалт, сэргийлэлтийн манай орны нөхцөлд тохирсон аргачлал зөвлөмж гаргана. Манай улсад бүртгэгдсэн шинэ короновируст халдвар (КОВИД-19)-ын эмнэлзүйн судалгаа хийсэн байна. | КОВИД-19 халдварын судалгааны нэмэлт санхүүжилтийн асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн төсвийн тодотголоор КОВИД-19 халдварын судалгаанд 2.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэсэн.<br>Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/262 дугаар тушаалаар судалгааны тэргүүлэх чиглэл болон ажлын хэсгийн бүрэлдэхүүн, удирдамжийг баталсан.<br>Коронавируст халдварын чиглэлээр ёс зүйн зөвшөөрөл бүхий 13 судалгааны төсөл хэрэгжиж, үр дүнг нь хүлээн авсан. Үүнд:<br>- SARS-CoV-2-ын нутгийн омгуудын геномын бүтцийг тодорхойлж, молекул эпидемиологийн онцлогийг тогтоон, онош, тандалт, сэргийлэлтийн манай орны нөхцөлд тохирсон арга, хэрэгслэл зохион бүтээх;<br>- Хүн амын янз бүрийн давхрага, эмзэг бүлгийнхний дотор anti-CoV, anti-SARS-CoV2 IgM, IgG тархалтыг судлаж, онош, тандалт, сэргийлэлт ашиглах чиглэлийг | БТГ-СТХ, НЭМГ<br><br>II улирал | **100.0** |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв, 2021 он (сая төгрөг), Эх үүсвэр | 2021 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр | Хариуцах газар, хэлтэс | Үнэлгээ-ний хувь, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тодорхойлох;<br>- Манай оронд тохиолдож буй КОВИД-19 халдварын эмнэлзүйн илрэлийг судлаж, онцлогийг тодорхойлон эмчлэн илааршуулах оновчтой аргыг боловсруулах;<br>- Манай оронд тохиолдож буй улирлын коронавируст халдварын эпидемиологи, эмнэлзүйн онцлогийг судлан тогтоож, сэргийлэх, эмчлэх оновчтой арга замыг тогтоох, Вакцин хэрэглэх нас, хүрээ, дэс дарааллыг тогтоож, тохиолдож болох бэрхшээлийг даван туулах аргуудыг тооцоолох;<br>- Манай орны нөхцөлд тохирсон, ДЭМБ-ын шаардлагыг хангасан оношлуур, эм, биобэлдмэл, бусад тоног төхөөрөмж, хэрэглүүр зохион бүтээж үйлдвэрлэн хангах.<br>Судалгааны нийт 40 ажлын үр дүнгийн эмхэтгэл боловсруулж гаргасан.<br>ХӨСҮТ-д SARS-CoV-2 вирүсийн хэв шинж, генийн дараалглыг тогтоох NGS шинжилгээний лаборатори байгуулж, SARS CoV-2 вирусын генийн дараалдыг тогтоох тандалтыг ДЭМБ-ын стратеги зөвлөмжид тулгуурлан хийж эхлээд байна. | | |
| 6 | 1.1.2. КОВИД-19 халдварт цар тахлын эрсдэлээс урьдчилан | 8.Олон улсын байгууллагатай хамтарсан коронавируст халдвар (КОВИД- | 2020-2024 | 800.0<br>Олон улсын байгууллага (ДЭМБ) | Шинэ коронавирусийн ийлдэс тархвар зүй хүн амын насны бүлгийн бүлэгт | Монгол Улсад бүртгэгдсэн тохиолдлын болон хавьтлын судалгааг 2021 оны эхний хагас жилд Улаанбаатар, Дархан-Уул, Дорноговь, Сэлэнгэ, Орхон, Говьсүмбэр зэрэг 5 аймагт | БТГ-СТХ, НЭМГ<br><br>I-IV улирал | **100.0** |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв, 2021 он (сая төгрөг), Эх үүсвэр | 2021 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр | Хариуцах газар, хэлтэс | Үнэлгээ-ний хувь, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | сэргийлж, бэлэн байдлыг хангахтай холбоотой төсвийн санхүүжилтийг нэмэгдүүлнэ | 19) судалгааны ажлуудыг эхлүүлэх, үр дүнг хүлээн авна | | | суурилсан судалгаа хийсэн байна. | бүртгэгдсэн дотоодын 150 тохиолдол, тэдгээрийн ойрын хавьтлыг хамруулан хийж судалгааны үр дүнг хүлээн авсан.<br>ДЭМБ-ын UNITY STUDY төслийн хүрээнд хийгдэж буй “Шинэ коронавирусын ийлдэс, тархвар зүй, насны бүлэгт суурилсан судалгаа”-г хийсэн.<br>Хүн амын дундах КОВИД-19 халдварын эсрэг ийлдсийн эсрэгбиеийн тархалтын зураглалыг судлахад 2020 оны 10-12 дугаар сарын байдлаар Монгол Улсын хүн амын дунд SARS-CoV-2-ийн эсрэг эсрэгбиеийн илэрц 1.44% байна. Судалгаанд хамрагдсан хүмүүсээс эмнэлзүйн ямар нэг шинж тэмдэг илэрсэн өгүүлэмжтэй, эсрэгбиеийн илэрц бүхий хувь 0.41%-ийг эзэлж байсан. Судалгаанд хамрагдсан хүн амын 90.6% нь дараагийн шатны буюу 3 сарын дараах шинжилгээнд хамрагдсан ба ийлдсийн эсрэгбиеийн үзүүлэлт 1.63% болж өссөн. Эдгээр иргэдээс эмнэлзүйн шинж тэмдэг бүхий хувь урд түвшинтэй ижил буюу 0.42% эзэлж байна. Судалгааны үр дүнг “Монгол Улс дахь SARS-CoV-2 вирусийн эсрэг биеийн тархалт: хүн ам, насны бүлэгт суурилсан судалгаа” сэдэвт эрдэм шинжилгээний өгүүллүүдийг салбартаа тэргүүлэх олон улсын, нэр хүнд бүхий the Lancet | | |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв, 2021 он (сая төгрөг), Эх үүсвэр | 2021 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр | Хариуцах газар, хэлтэс | Үнэлгээ-ний хувь, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Regional Health-Western Pacific сэтгүүлд нийтлэгдсэн | | |
| 7 | | | 2020-2024 | 80.0 Олон улсын байгууллага (ДЭМБ) | Монгол Улсад бүртгэгдсэн тохиолдлын болон хавьтлын судалгаа хийсэн байна. | Монгол Улсад бүртгэгдсэн тохиолдлын болон хавьтлын судалгааг 2021 оны эхний хагас жилд Улаанбаатар, Дархан-Уул, Дорноговь, Сэлэнгэ, Орхон, Говьсүмбэр зэрэг 5 аймагт бүртгэгдсэн дотоодын 150 тохиолдол, тэдгээрийн ойрын хавьтлыг хамруулан хийж судалгааны үр дүнг хүлээн авсан. | НЭМГ- ХӨХ | **100.0** |
| 8 | 1.1.3. Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас сэргийлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангана. | 1.Хариу арга хэмжээний нөөцийн бэлэн байдлыг бүрдүүлнэ. | 2021-2024 | | | - 2021 оны 1 дүгээр сарын 4-ний өдөр АНУ-ын ЭСЯ-нд хандаж хүсэлт гарган, цахим уулзалтуудыг зохион байгуулсны үр дүнд 450,000 ам. долларын (1.2 тэрбум төгрөг) үнэ бүхий хувийн хамгаалах хэрэгсэл, КОВИД-19 антиген илрүүлэх түргэвчилсэн оношлуурыг буцалтгүй тусламжаар хүлээн авах тухай албан шийдвэрийг 1-р сарын 14-ний өдөр ЭСЯ-наас хүлээн авсан. Энэ дагуу 30,000 ширхэг STANDARD Q COVID-19 Ag Test (SD Biosensor), 24,000 ширхэг нүүрний хамгаалалт, 85,000 ширхэг N95 амны хаалт, 3,150 хайрцаг бээлийг тусламжаар хүлээн авч Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/126 дугаар тушаалаар эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилсан. Тушаалд хамрагдаагүй хэсгийг Эрүүл мэндийн сайдын зөвшөөрснөөр ОБЕГ болон МХЕГ-т хүлээлгэж өгсөн.<br>- 2021 оны 2 дугаар сард БНФУ- | НЭМГ, ЭЭХХЗГ | **100.0** |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв, 2021 он (сая төгрөг), Эх үүсвэр | 2021 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр | Хариуцах газар, хэлтэс | Үнэлгээ-ний хувь, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | аас 54,000 евро буюу 184 сая төгрөгийн үнэ бүхий хүчилтөрөгчийн хангамжийн хэрэгслүүдийг хүлээн авч ГССҮТ-д олгосон.<br>- Дэлхийн банкинд хандаж хүсэлт гаргасны дагуу 1 сая ам.доллар буюу 2.8 тэрбум төгрөгийн үнэ бүхий хувийн хамгаалах хэрэгслийг буцалтгүй тусламжаар хүлээн авч эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилсан.<br>- 2021 оны 4 дүгээр сард БНХАУ-ын ЭСЯ-нд хандаж дэмжлэг хүссэний дагуу 2021 оны 5 дугаар сард 2.6 тэрбум төгрөгийн үнэ бүхий хувийн хамгаалах хэрэгсэл болон PCR оношлуурыг хүлээн авсан.<br>- ХБНГУ-ын Холбооны Эрүүл мэндийн яамнаас 145,068 ам.доллар буюу 413 сая гаруй төгрөгийн үнэ бүхий 462,000 ширхэг мэс заслын амны хаалтыг 5 дугаар сард хүлээн авсан.<br>Хариу арга хэмжээний нөөцийн бэлэн байдлыг бүх эрүүл мэндийн байгууллагаас цахимаар burtgel.mohs.mn авч, хувийн хамгаалах хэрэгсэл, эм, ариутгал, халдваргүйтгэлийн бодисын нөөцөд хяналт тавьж байна. Эмийн нөөцийг вирусийн эсрэг эм, антибиотик, амилуулах тусламж, үйлчилгээний нөөц гэсэн ангиллаар, лабораторийн нөөцийг ПГУ-ын ялгах оношлуур, | | |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв, 2021 он (сая төгрөг), Эх үүсвэр | 2021 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр | Хариуцах газар, хэлтэс | Үнэлгээ-ний хувь, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шүлсний оношлуур, түргэвчилсэн оношлуур гэсэн ангиллаар, хувийн хамгаалах хэрэгслийг амны хаалт, халат, бээлий малгай гэх мэт зүйл тус бүрээр, амьсгалын аппарат, вакцины нөөц төрлөөр өдөр бүр гаргаж, удирдлагын мэдээллээр хангаж байна. 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар улсын хэмжээнд 11 нэр төрлийн вирусийн эсрэг 27.1 тэрбум төгрөгийн эм, 9 нэр төрлийн 1.5 тэрбум төгрөгийн антибиотик, ПГУ-ын тодорхойлох оношлуур 512,743, ПГУ-ын ялгах оношлуур 417,827, шүлсний ПГУ-ын оношлуур 156, хамар залгиурын түргэвчилсэн оношлуур 383,743, Gene Expert оношлуур 84 ширхэг нөөцтэй байна. Дэлхийн банкны "Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үеийн хариу арга хэмжээ, эрүүл мэндийн тогтолцооны бэлэн байдлыг хангах" төслийн хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр, НҮБ-ын Хүүхдийн сангийн техник хамтын ажиллагааны хүрээнд 2.0 сая ам.долларын өртөг бүхий 1,686 м$^2$ талбайтай, өдөрт 100 кг хуурай мөс үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэр бүхий орчин үеийн тоног төхөөрөмжөөр тоноглосон, дэвшилтэт технологи, шийдэлтэй, олон улсын стандартын шаардлагад нийцсэн цогц "Вакцин, биобэлдмэлийн төв агуулахын | | |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв, 2021 он (сая төгрөг), Эх үүсвэр | 2021 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр | Хариуцах газар, хэлтэс | Үнэлгээ-ний хувь, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өргөтгөл"-ийн барилгыг 2021 оны 08 дугаар сарын 24-ний өдөр ашиглалтад оруулсан.<br>Мөн 2.3 тэрбум төгрөгийн хөргөгч, хөлдөөгч, хэмийн хяналтын хэрэгслээр аймаг, нийслэлийн дархлаажуулалтын 580 нэгжийг ханган, вакцины хүйтэн хэлхээний багтаамжийг нэмэгдүүлээд байна. | | |
| 9 | | 2.Шаардлагатай аймгуудад зоонозын өвчин судлалын төв, хил дагуух боомтод тандалтын нэгж байгуулна. | 2021-2023 | 2,400.0 Улсын төсөв | Хил дагуух 4 боомтод тандалтын нэгж байгуулсан байна. 1 аймагт Зоонозын өвчин судлалын төвийг ашиглалтад оруулсан байна. | Дорноговь, Орхон 2 аймагт шинээр Зоонозын өвчин судлалын төв, Сэлэнгэ, Дорнод, Дорноговь, Сүхбаатар, Өмнөговь, Ховд, Баян-Өлгий, Увс, Хөвсгөл зэрэг 10 аймгийн хил дагуух боомтод тандалтын нэгж байгуулахаар тооцоо судалгааг хийсэн. Дээрх 2 аймагт Зоонозын өвчин судлалын төв байгуулахад 550.0 сая төгрөг, хил дагуух боомт-д тандалтын 1 нэгж байгуулахад 1.2 сая төгрөг шаардлагатай гэсэн тооцоо гарсан.<br>Дорноговь аймгийн Замын-Үүд, Өмнөговь аймгийн Гашуунсухайт боомтод коронавируст халдварын идэвхтэй тандалтын нэгж байгуулсан.<br>Дархан-Уул, Дорноговь, Дорнод аймагт Зоонозын өвчин судлалын төв байгуулах талаар үндэслэл, танилцуулга, шаардагдах төсвийн төслийг хийсэн.<br>Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үед хилийн нэвтрэх цэгийн тандалтыг сайжруулах үүднээс Өмнөговь аймгийн | НЭМГ, СЭЗГ-ХОХ<br><br>I-IV улирал | **50.0** |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв, 2021 он (сая төгрөг), Эх үүсвэр | 2021 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр | Хариуцах газар, хэлтэс | Үнэлгээ-ний хувь, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Ханбогд сумын Хайрхан багийн Цагаан хадны нутаг дэвсгэрт орших “Гашуун сухайт” хилийн боомтод нүүрс экспортын тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагын жолооч, ажилчдын молекул биологийн шинжилгээ хийх, тохиолдлын тандалт судалгаа хийх зорилгоор 2021 оны 09 дүгээр сарын 26-наас ХӨСҮТ-ийн баг томилогдон 14 хоногийн давтамжтай солигдон ажиллаж байна. 2021 оны 11 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн Чингис хаан агаарын боомт, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Баян-Өлгий аймгийн Цагааннуур, Увс аймгийн Боршоо, Өмнөговь аймгийн Гашуунсухайт автозамын боомтуудад коронавируст халдварын идэвхтэй тандалт хийж байна.<br>SARS-Cov-2 вирусийн Омикрон хувилбар бүртгэгдсэнтэй холбоотой хилийн нэвтрэх цэгийн хяналтыг сайжруулахаар Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/734 дүгээр тушаалыг батлуулсан. ЭМЯ, ХӨСҮТ, ЗӨСҮТ, НЭМҮТ-ээс олон улсын нисэх онгоцны буудал, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Увс аймгийн Боршоо, Дорнод аймгийн Эрээнцав, Баянхошуу боомтод мэргэжлийн баг ажиллаж, бэлэн байдалтай танилцан, дэмжлэгт хяналт хийсэн. Мөн Омикроны хилийн тандалт | | |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв, 2021 он (сая төгрөг), Эх үүсвэр | 2021 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр | Хариуцах газар, хэлтэс | Үнэлгээ-ний хувь, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хийх зорилгоор сорьц цуглуулах цэгүүдийг олон улсын нисэх онгоцны буудал, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Увс аймгийн Боршоо Баян-Өлгий аймгийн Цагааннуур, Өмнөговь аймгийн Гашуунсухайт, Гурван Тэс боомтод ажиллуулж байна. | | |
| 10 | | 3.Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгаа зохион байгуулна. | 2021-2024 | 100.0 Улсын төсөв | Төлөвлөгөөт сургалт, сурталчилгаа бүрэн хийгдсэн байна. | Коронавируст халдвар (КОВИД-19)-аас сэргийлэх болон вакцинжуулалтыг эрчимжүүлэх мэдээлэл сурталчилгааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж байна.<br>-Коронавируст халдварын нөхцөл байдлын хэвлэлийн хурлыг 249 удаа зохион байгуулж Эрүүл мэндийн яамны фейсбүүк хаягаар шууд (Live) дамжуулахад давхардсан тоогоор 46,259,026 хүн хандалт хийж, 29,256 хүн мэдээллийг хуваалцсан байна.<br>- Коронавируст халдвар (КОВИД-19)-аас сэргийлэх чиглэлээр 217 төрлийн инфографик, 109 удаагийн мэргэжлийн эмчийн зөвлөмж, 124 видео шторк, 46 төрлийн зөвлөмж (текст) бэлтгэн Эрүүл мэндийн яамны фэйсбүүк хуудсанд байршуулан давхардсан тоогоор 76,998,256 иргэдэд мэдээлэл хүргэж, 201,056 гаруй хүн хуваалцсан байна.<br>- Дэлхийн улс оронд бүртгэгдэж байгаа шувууны томуу өвчнөөс сэргийлэх талаар 3 төрлийн инфографик, хачигт халдвараас сэргийлэх талаар 8 төрлийн инфографик, зурагт хуудсыг | НЭМГ- ХӨХ<br><br>I-IV улирал | **100.0** |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв, 2021 он (сая төгрөг), Эх үүсвэр | 2021 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр | Хариуцах газар, хэлтэс | Үнэлгээ-ний хувь, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | боловсруулан түгээсэн.<br>- 2021 оны 07 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн Коронавируст халдварын нөхцөл байдлын мэдээллийг постер хэлбэрээр түгээж эхэлсэн бөгөөд 296 удаа бэлтгэн нийтэлсэн.<br>2020 оны 03 дугаар сарын 10-ны өдрөөс НЭМҮТ-д коронавируст халдвар (КОВИД-19)-ын талаарх мэдээлэл, зөвлөгөө өгөх 119 дугаар ажиллаж эхэлсэн.<br>Мэдээлэл, сурталчилгааг эрчимжүүлэхээр 18 телевиз, 6 гудамжны дэлгэц мөн цахим мэдээллийн сайтуудаар 10 видео контент, 12 инфографикийг түгээн хамтран ажиллаж байна. Үүнд:<br>- Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба Чингисийн талбай, Төв хаан банкны дэлгэц, 9 сайт, 36 пэйж хуудсаар<br>- МҮОНТВ, ТВ9, Стар ТВ, ETV, VTV, Малчин, Централ телевизүүд<br>- Авто тээврийн үндэсний төв хот хоорондын 690 том оврын автобусны дэлгэцээр<br>- МҮОНТВ-ээр КОВИД-19-Вакцин сэдвээр 4, КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөгөө, зөвлөмж бүхий 5 төрлийн видео контентыг бэлтгэн хүргүүлж, 05 дугаар сарын 16-ны өдрөөс түгээж эхэлсэн.<br>-2021 оны 07 дугаар сарын 11-ний | | |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв, 2021 он (сая төгрөг), Эх үүсвэр | 2021 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр | Хариуцах газар, хэлтэс | Үнэлгээ-ний хувь, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өдрөөс хойш Коронавируст халдвар (КОВИД-19)-ын нөхцөл байдлын мэдээллийг инфо хэлбэрээр гаргаж олон нийтэд хүргэдэг болсон. 76 удаа түгээсэн бөгөөд уг мэдээлэл нь өдөр бүр 30 телевиз, 40 сайтаар цацагдаж байна.<br>Шадар сайдын Ажлын албанаас шинээр нээсэн "КОВИД-ын тусламж, зөвлөгөө" фэйсбүүк пэйж хуудсанд өдөр тутам 5-аас доошгүй мэдээлэл сурталчилгааны материалыг оруулж байна. | | |
| 11 | | 4.Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн нөөцийн агуулах шинэчлэн барьж, ашиглалтад оруулна. | 2020-2024 | 1,000.0 Гадаадын зээл, тусламж (АХБ) | Барилгын ТЭЗҮ боловсруулж батлуулсан байна. | Азийн хөгжлийн банкны "Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-5" төслийн яаралтай тусламжийн зээлийн санхүүжилтээр Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн дэргэд онцгой байдлын үеийн эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн агуулахын байрыг барьж, 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдөр дуусгасан (7.3 тэрбум төгрөг). Улсын комисст 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдөр хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна. | СЭЗГ- ХОХ<br>I-IV улирал | **100.0** |
| 12 | | 6.Шинэ коронавирусийн халдварыг тодорхойлох оношлуурыг дотооддоо бүтээн, турших, хэрэглээнд | 2021-2024 | Улсын төсөв | Оношлуурын бүрдлийг хэрэглээнд нэвтрүүлсэн байна. | Шинэ коронавирусийн SARS-COV-2 вирусийн халдварыг шүлснээс илрүүлэх АШУҮИС-ийн эрдэмтдийн бүтээсэн ПГУ/PCR оношлуурыг 2021 оны 03 дугаар сараас оношилгоонд нэвтрүүлсэн. Коронавируст халдварыг шүлсэнд тодорхойлох 1.3 тэрбум төгрөгийн 200 мянган ширхэг | ЭТҮГ, НЭМГ<br>I-IV улирал | **100.0** |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв, 2021 он (сая төгрөг), Эх үүсвэр | 2021 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр | Хариуцах газар, хэлтэс | Үнэлгээ-ний хувь, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | нэвтрүүлнэ. | | | | түргэвчилсэн оношлуурыг худалдан авч, эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилсан. | | |
| 13 | | 7.Аймгийн нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо эмчилгээний төвүүдийн Молекул биологийн лабораторийн чадавхийг бэхжүүлнэ | 2021-2024 | 1,000.0 Гадаадын зээл, тусламж | 5 аймгийн НЭ, БОЭТ-д БХ-ПГУ төхөөрөмжтэй болж, лабораторийн чадавх нэмэгдсэн байна. | Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын эсрэг хариу арга хэмжээний чадавхийг бэхжүүлэх хүрээнд эрүүл мэндийн байгууллагуудад коронавируст халдварын оношилгоо, эмчилгээ, ялган оношилгоог сайжруулахаар зорилгоор 2021 онд 6.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт бүхий молекул биологийн лаборатори байгуулсан. 2021 онд улсын хэмжээнд 17 аймаг (Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Дархан-Уул, Сэлэнгэ, Увс, Хөвсгөл, Хэнтий, Дорноговь, Булган, Төв, Говьсүмбэр, Сүхбаатар, Дундговь, Завхан, Говь-Алтай), нийслэлийн 8 дүүрэг (Багануур, Баянгол, Баянзүрх, Налайх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй), Шивээхүрэн, Гашуунсухайт зэрэг хилийн боомт, нийт 27 газар бодит хугацааны ПГУ, нуклеин хүчил ялгах тоног төхөөрөмжөөр хангаж молекул биологийн лаборатори байгуулсан.<br>Мөн ХӨСҮТ-ийн Вирус судлалын лаборатори, ЗӨСҮТ, Дорноговь аймгийн нэгдсэн эмнэлэг, Замын-Үүд сумын нэгдсэн эмнэлгийн лабораторид PCR аппарат, нуклейн хүчил ялгагч аппаратыг шинээр нэмж суурилуулан, | ЭТҮГ, СЭЗГ-ХОХ<br><br>I-IV улирал | **100.0** |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв, 2021 он (сая төгрөг), Эх үүсвэр | 2021 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр | Хариуцах газар, хэлтэс | Үнэлгээ-ний хувь, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүчин чадлыг нэмэгдүүлсэн. 2021 оны 01 дүгээр сард 80 лабораторийн эмч, эмнэлгийн мэргэжилтнийг ХӨСҮТ, ЗӨСҮТ, НЭМҮТ, УНТЭ, УХТЭ-ийн лабораторид 14 хоногоос 2 сарын хугацаатай дагалдуулан сургаж бэлтгэсэн. Лабораторийн мэргэжлийн салбар зөвлөлтэй хамтран бүх лабораторийн эмч, мэргэжилтнүүдэд Молекул биологийн лабораторийн үйл ажиллагаа, лабораторийн аюулгүй ажиллагаа, шинжилгээний заавар, сорьц авах, зөөвөрлөх г.м сэдвүүдээр сургалт зохион байгуулсан. | | |
| 14 | 1.1.4. "КОВИД-19" халдварт вирусийн оношилгоо, эмчилгээнд зориулж импортлох оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодисыг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан | 1.Гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлүүлэх эм, эмнэлгийн хэрэгсэл, тэдгээрийн түүхий эд, оношлуур, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодисын жагсаалтыг шинэчлэн боловсруулна | 2020-2021 | - | Шинэчилсэн жагсаалтын дагуу татвараас чөлөөлөгдөж, хариу арга хэмжээний нөөцийн бэлэн байдлыг бүрдүүлнэ. | Монгол Улсын Шадар сайд, Эрүүл мэндийн сайдын 2020 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 163/А/603 дугаар хамтарсан тушаалаар цар тахлын болон нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг авахад шаардлагатай нөөцөд байх эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйтгэлийн бодисын жагсаалтыг шинэчлэн баталсан. Засгийн газрын 2021 оны 274 дүгээр тогтоолоор “Коронавируст халдвар (КОВИД-2019)-ын оношилгоо, эмчилгээнд хэрэглэх гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж, оношлуур, тоног төхөөрөмж, | ТЗУГ<br><br>I-IV улирал | **100.0** |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв, 2021 он (сая төгрөг), Эх үүсвэр | 2021 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр | Хариуцах газар, хэлтэс | Үнэлгээний хувь, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | татвараас 2020 оныг дуустал үргэлжлүүлэн чөлөөлнө. | | | | | ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис, “Ремдесивир” тарилгын уусмалын БТКУС код “3004.90.10”-ыг нэмэлтээр оруулсан. Мөн Засгийн газрын 2021 оны 379 дүгээр тогтоолоор “Коронавируст халдвар (КОВИД-2019)-ын оношилгоо, эмчилгээнд хэрэглэх оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодисын жагсаалтад Тоцилизумаб, Касиривимаб, Молнупиравир, Паксловид (PF-07321332) зэрэг эмийг нэмсэн. | | |
| **ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | | | | | |
| **2.1. Эрүүл мэнд. Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.** | | | | | | | | |
| 15 | 2.1.1.Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, иргэн бүр урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд тогтмол хамрагдах нөхцөлийг олон улсын жишигт нийцүүлэн | 1."Эрүүл, идэвхитэй амьдрал" арга хэмжээ хэрэгжүүлнэ | 2021-2024 | - Улсын төсөв | Арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлуулна. | Эрүүл мэндийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/780 дугаар тушаалаар “Эрүүл идэвхтэй амьдрал” 2021-2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулсан. | НЭМГ-ХБӨХ I-IV улирал | **100.0** |
| 16 | | 2."Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх" арга хэмжээ хэрэгжүүлнэ | 2021-2024 | 10,000.0 Улсын төсөв (ЭМДС) | Арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж батлуулна. Арга хэмжээний хэрэгжилт 30 хувь | “Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах” үндэсний хөтөлбөр (2017-2020)-ийн хэрэгжилтэд үнэлгээ хийх, халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийг Эрүүл мэндийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн А/635 дугаар тушаалаар байгуулсан. Ажлын хэсгийн хурлыг 3 удаа зохион | НЭМГ- ХӨХ I-IV улирал | **30.0** |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв, 2021 он (сая төгрөг), Эх үүсвэр | 2021 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр | Хариуцах газар, хэлтэс | Үнэлгээ-ний хувь, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | сайжруулж, эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ. | | | | | байгуулж, "Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах" үндэсний хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт, төлөвлөгөөний биелэлтийг гаргасан. | | |
| 17 | | 3."Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд" арга хэмжээ хэрэгжүүлнэ | 2021-2024 | 2,900.0 Улсын төсөв, Гадаадын зээл, тусламж (НҮБ-ын Хүүхдийн сан) | Арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж батлуулна. Арга хэмжээний хэрэгжилт 30 хувь | "Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд" 2021-2024 оны арга хэмжээний төлөвлөгөөг Эрүүл мэндийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/760 дугаар тушаалаар батлуулсан. | НЭМГ-ХБӨХ, ЭМТҮГ<br><br>I-IV улирал | **70.0** |
| 18 | | 4."Хавдрын эсрэг" арга хэмжээ хэрэгжүүлнэ | 2020-2024 | 500.0 Улсын төсөв (ЭМДС) | Хорт хавдрын эрт илрүүлэх үзлэгийн хамралтын хүрэх түвшин 40 хувьд хүргэнэ. | "Хавдрын эсрэг 2021-2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/360 дугаар тушаалаар батлуулсан. Эрүүл мэндийн сайдын 2021 оны "Хүүхдийн хорт хавдартай тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай" А/201 дүгээр тушаал батлуулж, хүүхдийн хорт хавдрын тусламж, үйлчилгээ, хяналтыг сайжруулах 2021-2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлж байна.<br>"Хавдрын эсрэг" арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу зонхилон тохиолдох хавдраас сэргийлэх, тусламж, үйлчилгээний хамралтыг сайжруулах чиглэлээр дараах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн:<br>- Хавдрын эрт илрүүлэг үзлэгийн | НЭМГ-ХБӨХ<br><br>I-IV улирал | **70.0** |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв, 2021 он (сая төгрөг), Эх үүсвэр | 2021 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр | Хариуцах газар, хэлтэс | Үнэлгээний хувь, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хамрагдалтыг нэмэгдүүлэхэд хүн бүр хүчин чармайлт гаргахыг уриалсан ХСҮТ-ийн ажилчид оролцсон 14 төрлийн видео шторк болон 14 төрлийн постерыг хийж, бүх аймаг, дүүргийн хавдрын кабинет болон олон нийтийн сүлжээгээр түгээсэн.<br>- “Умайн хүзүүний хорт хавдрын цогц хяналтын заавар”-ын хэрэгжилтийг хангах арга зүйн сургалтыг Өвөрхангай, Дорнод, Өмнөговь аймагт зохион байгуулсан. Шинжилгээний хүлээгдлийг бууруулах зорилгоор “Умайн хүзүүний эсийн шинжилгээ авах аргачлал” сэдэвт 6 цагийн цахим сургалтыг зохион байгуулж, 9 дүүргийн 18 эмэгтэйчүүдийн эмч, эс судлаач нарыг хамруулсан.<br>- 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдөр Хавдар судлалын үндэсний төвд Хөхний төв байгуулж, үйл ажиллагааг эхлүүлсэн. Уг төв нээгдсэнээр хөхний бүх төрлийн эмгэгийн үеийн тусламж, үйлчилгээг цогцоор нь үзүүлж, үзлэгийн чанар сайжирч, хөхний хортой хавдрын хагалгааны болон орны хүлээгдэл эрс буурсан.<br>- Хорт хавдрын эрт илрүүлгийн бүртгэлийг сайжруулахаар www.screening.gov.mn программд | | |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв, 2021 он (сая төгрөг), Эх үүсвэр | 2021 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр | Хариуцах газар, хэлтэс | Үнэлгээ-ний хувь, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | умайн хүзүү, хөхний модулийн нэмэлт хөгжүүлэлт хийгдсэн. Уг програм хангамжийн 2 цагийн цахим сургалтыг зохион байгуулж, 21 аймаг 9 дүүргийн 30 хавдар бүртгэгч нарыг хамруулсан.<br>- 2021 оны жилийн эцсийн байдлаар улсын хэмжээнд умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэгт 67,308 эмэгтэй хамрагдаж, зорилтот насны эмэгтэйчүүдийн эрт илрүүлэгт хамрагдалт 26.6 хувьд хүрсэн байна. Хөхний хорт хавдрын илрүүлэгт улсын хэмжээнд нийт 366,918 эмэгтэй буюу зорилтот насны эмэгтэйчүүдийн 35.9 хувь нь хамрагдаж, үүнээс 1,341 эмэгтэй эмнэл зүйн шинжилгээгээр эерэг гарч, 10 хүнд хөхний өмөн оношлогдсон байна. Элэгний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт 40-65 насны 182,270 (21.6%) хүн хамрагдсанаас 122 тохиолдолд хорт хавдар оношлогдсон байна.<br>- Коронавируст халдвартай холбоотойгоор хорт хавдрын эрт илрүүлэх үзлэгийн хамралт зорилтот түвшинд хүрээгүй байна. | | |
| 19 | | 5."Элэг бүтэн Монгол" арга хэмжээ хэрэгжүүлнэ | 2021-2024 | 17,000.0 Улсын төсөв (ЭМДС) | Арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, Засгийн газрын тогтоолоор | “Элэг бүтэн Монгол” арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийг Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/629 дүгээр тушаалаар байгуулан ажиллаж байна. | ЭТҮГ<br><br>I-II улирал | **30.0** |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв, 2021 он (сая төгрөг), Эх үүсвэр | 2021 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр | Хариуцах газар, хэлтэс | Үнэлгээ-ний хувь, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | батлуулан, хэрэгжүүлж эхэлсэн байна. | | | |
| 20 | | 6."Харшлаас сэргийлэх" арга хэмжээг хэрэгжүүлнэ | 2021-2024 | - Улсын төсөв, Гадаадын зээл, тусламж | Арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, Засгийн газрын тогтоолоор батлуулан, хэрэгжүүлж эхэлсэн байна. | "Харшлаас сэргийлэх" арга хэмжээний төлөвлөгөөг Эрүүл мэндийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/816 дугаар тушаалаар батлуулсан. Тушаалыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлж эхлэнэ. | НЭМГ-ХБӨХ II улирал | **90.0** |
| 21 | | 7."Эрүүл чийрэг эр хүн" арга хэмжээ хэрэгжүүлнэ | 2021-2024 | - Улсын төсөв, Гадаадын зээл, тусламж (НҮБ-ын Хүн амын сан) | Арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, Засгийн газрын тогтоолоор батлуулан, хэрэгжүүлж эхэлсэн байна. | "Эрүүл чийрэг эр хүн" 2021-2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Эрүүл мэндийн сайдын 2021 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн А/559 дүгээр тушаалаар батлуулсан. Улсын хэмжээнд урологи-андрологийн чиглэлээр тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эрэгтэйчүүдийн тасаг, кабинет ажиллуулж байгаа төр, хувийн хэвшлийн нийт 20 эмнэлгийн үйл ажиллагаа, хүний нөөцийн дэлгэрэнгүй судалгааг гаргасан. | НЭМГ-ХБӨХ II улирал | **100.0** |
| 22 | 2.1.2. "Элэг бүтэн Монгол" арга хэмжээний үр ашиг, өгөөж, хүртээмжийг нэмэгдүүлж, элэгний Д вирусийн халдвартай | 1."Элэг бүтэн Монгол" арга хэмжээний үр ашгийн судалгаа хийнэ | 2021-2022 | - Улсын төсөв | Судалгаа хийж, тайлан гаргасан байна. | "Элэг бүтэн Монгол" арга хэмжээний үр ашгийн судалгаа хийх ажлын хүрээд ДЭМБ-тай 3 удаа уулзалт зохион байгуулсан. Мөн Булган, Орхон аймаг, Сонгинохайрхан, Баянзүрх дүүрэгт вируст гепатитын эмнэлгийн тусламж, үйлчилгээний үр нөлөөллийн судалгаа, үнэлгээг зохион байгуулсан. Судалгааны хүрээнд цуглуулсан тоо | ЭТҮГ I-IV улирал | **30.0** |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв, 2021 он (сая төгрөг), Эх үүсвэр | 2021 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр | Хариуцах газар, хэлтэс | Үнэлгээ-ний хувь, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | иргэдийн 50-аас дээш | | | | | баримтад дүн шинжилгээг хийх ажил хийгдэж байна. | | |
| 23 | хувийг эмчилгээнд хамруулж, хорт хавдрын эрт илрүүлгийг олон улсын жишигт хүргэнэ. | 2.Д вирустэй иргэдийг эмчилгээнд хамруулна | 2021 - 2024 | 1,000.0 Улсын төсөв (ЭМДС) | Эмчилгээнд хамрагдах хувийг 10 хувьд хүргэнэ. | Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлттэй уялдуулан гепатитын В, С, Д вирусын халдварын илрүүлэг, оношилгоо, эмчилгээний зааврыг шинэчлэн боловсруулах ажил хийгдэж байна. Хүний эмийн зөвлөлөөр элэгний Д вирусын эсрэг “Bulevirtide (Hepcludex) эмийг өнчин эмийн жагсаалтад 2 жилийн хугацаатай 2021 оны 05 дугаар сард бүртгэж, Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/347 дугаар тушаалаар баталгаажуулсан. Д вирустэй иргэдийг эмчилгээнд хамруулж эхлээгүй байна. | ЭМТҮГ, СЭЗГ-СДХ<br><br>I-IV улирал | **50.0** |
| 24 | 2.1.3. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан иргэд эх орондоо оношлогдон, эмчлүүлэх боломжийг нэмэгдүүлж, орчин үеийн үндэсний оношилгоо, эмчилгээний | 2.Зүрх судасны төв байгуулна | 2021-2024 | 10,000.0 Гадаадын зээл, тусламж | Барилгын ажлын явц 10 хувьд хүрсэн байна. | Зүрх судасны төвийн зураг төсвийг Люксембургийн Засгийн газрын дэмжлэгтэй хэрэгжиж байгаа “Зүрх судасны төв байгуулах” төслийн 1.5 сая еврогийн буцалтгүй тусламжийн хүрээнд хийж магадлалаар баталгаажуулсан. Зураг төсвийн дагуу барилгын ажлын төсвийн эх үүсвэрийг 2021 оны улсын төсвийн тодотголд тусгах саналыг Сангийн яаманд 2021 оны 06 дугаар сард, 2022 оны улсын төсөвт тусгах саналыг Сангийн яаманд 2021 оны 08 дугаар сарын 15-нд хүргүүлсэн боловч батлагдаагүй. Төвийн барилгыг Улсын гуравдугаар төв эмнэлгийн хашаанд барихаар газрын асуудлыг шийдвэрлэсэн. | СЭЗГ-ХОХ<br><br>I-IV улирал | **30.0** |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв, 2021 он (сая төгрөг), Эх үүсвэр | 2021 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр | Хариуцах газар, хэлтэс | Үнэлгээ-ний хувь, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 25 | төвүүдийг шинээр байгуулна. | 3.Сүрьеэгийн эмнэлэг барьж, ашиглалтад оруулна | 2021-2023 | 2,000.0 Улсын төсөв | Барилгын ажлын явц 2021 онд 30 хувьтай байна. | Сүрьеэгийн эмнэлгийн барилга угсралтын ажлын худалдан авах ажиллагааны зохион байгуулалт Засгийн газрын тогтоолоор Төрийн худалдан авах ажиллагааны газарт шилжсэн бөгөөд тухайн байгууллагаас гэрээ байгуулах эрх олгох зөвлөмж ирүүлээгүй байна. Төрийн худалдан авах ажиллагааны газраас гаргасан зөвлөмжид оролцогч компаниуд шүүхийн байгууллагад нэхэмжлэл гаргаснаар барилга угсралтын ажлын гэрээ байгуулагдаж чадаагүй байна. Шүүхийн шийдвэрийн дагуу дахин үнэлгээ хийгдэж байна. | СЭЗГ-ХОХ<br><br>I-IV улирал | **0** |
| 26 | | 4. Геронтологийн төвийн барилгын ажлыг дуусгаж, ашиглалтад оруулна | 2021-2022 | 12,000.0 | Барилгын ажлын явц 70 хувьтай байна. | Монгол Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрүүдээс Геронтологийн төвийн барилга царцсан, барилга угсралтын ажил хийгдээгүй байна. Шалтгаан нөхцөл нь барилга угсралтын ажлын зураг төсвийг бүрэн болгож, Барилгын хөгжлийн төвийн магадлалаар баталгаажуулахад төсөвт өртөг нэмэгдсэн бөгөөд төсөвт өртгийн нэмэгдлийг Сангийн яаманд 2020-2022 онуудын төсвийн тухай хуульд өргөн барьсан боловч батлагдаагүй. 2022 онд Үндэсний аудитын газраас дуусаагүй, олон жил үргэлжилж, хэрэгжилт нь удааширч байгаа төсөл, арга хэмжээнүүдэд чиглэсэн аудит хийх төлөвлөгөөнд уг барилгын ажлыг | СЭЗГ-ХОХ | **70.0** |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв, 2021 он (сая төгрөг), Эх үүсвэр | 2021 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр | Хариуцах газар, хэлтэс | Үнэлгээ-ний хувь, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тусгуулсан болно. Геронтологийн төвийн барилгын ажлын явц 46.0 хувьтай байна. | | |
| 27 | | 5.Түлэнхийн төвийн барилгыг ашиглалтад оруулна | 2021 | - | Ашиглалтад оруулсан байна. | Түлэнхийн төвийн барилга угсралтын ажил хэвийн үргэлжилж байна. 2021 оны 06 дугаар сарын 30-ны дотор байнгын ашиглалтад оруулах Улсын комисс ажиллуулахаар төлөвлөн ажиллаж байсан ч хугацаа 2021 оны 12 дугаар сарын 30-ны дотор болж хойшлогдсон. Барилга угсралтын ажлын явц 95 хувьтай байна. Улсын комисс ажиллуулах хүсэлтийг Хотын стандарт, хөгжлийн газарт хүргүүлсэн бөгөөд Улсын комисс ажиллуулахаар хүлээгдэж байна. | СЭЗГ-ХОХ<br><br>I-IV улирал | **90.0** |
| 28 | | 6.Халдварт өвчин судлалын үндэсний төвийн цогцолбор салбар II байгуулна | 2021-2024 | -<br>Улсын төсөв | Зураг төсөв ТЭЗҮ хийгдсэн байна. | Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулийн XII.4.2-д батлагдсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараа онуудад хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улсын хэмжээнд/” ажлын хүрээнд Зураг төсөл боловсруулах даалгавар боловсруулан БХБЯ-д хүргүүлсэн. Тус зураг төслийг UDC Group LLC шалгаран гүйцэтгэж, ажлын явц 70.0 хувьтай байна. | СЭЗГ-ХОХ<br><br>I-IV улирал | **70.0** |
| 29 | | 7.Хавдар судлалын үндэсний төвийн салбар II байгуулна | 2021-2024 | -<br>Улсын төсөв | Зураг төсөв ТЭЗҮ хийгдсэн байна. | Зураг төсөв боловсруулах даалгаврыг боловсруулан БХБЯ-д хүргүүлж, “Нийслэлийн зураг төслийн хүрээлэн” ХХК-тай гэрээ байгуулагдаж зургийн ажил хийгдэж байна. Хавдар судлалын үндэсний төвийн салбар II барилгыг | СЭЗГ-ХОХ<br><br>I-IV улирал | **70.0** |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв, 2021 он (сая төгрөг), Эх үүсвэр | 2021 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр | Хариуцах газар, хэлтэс | Үнэлгээ-ний хувь, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | барих нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар хороонд 8 га газрыг эзэмших гэрчилгээг 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдөр авсан ч газрын асуудал байгаа тул шийдвэрлэхээр Нийслэлийн Засаг даргад хандсан. | | |
| 30 | | 9.Нийслэлийн Хан-Уул дүүрэгт баригдаж байгаа 300 ор бүхий "Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв II"-ийн барилгын ажлыг дуусган, дэд бүтэц барих /концессын эргэн төлөлт/ | 2020-2021 | 30,778.7 Улсын төсөв | Концессын эргэн төлөлтийг бүрэн олгоно. Үйл ажиллагааг жигдрүүлнэ. | Коронавируст халдвар (КОВИД-19)-тай иргэдийг эмчилж байгаатай холбоотой Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв-II-ийн төсвийг нэмэгдүүлэн нийт 1.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэж, эмнэлгийн тусламж, үйлчилгээний тасралтгүй үйл ажиллагааг ханган ажиллаж байна. Дэлхийн банкны төслийн санхүүжилтээр Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв II-д эмнэлгийн тусламж, үйлчилгээнд нэн шаардлагатай нийт 30 орчим нэр төрлийн тоног төхөөрөмж нийлүүлсэн.<br>2021 оны улсын төсөвт 30.7 тэрбум төгрөг ЭНЭҮТ-II-ын концессын эргэн төлөлт хийхээр баталсан. 2021 оны III улирлын байдлаар концессын эргэн төлөлт бүрэн олгогдсон байна. | СЭЗГ-ХОХ<br>I-IV улирал | **100.0** |
| 31 | | 11.Захиалгын дагуу барилга байгууламжийн нэг маягийн болон давтан хэрэглэх зураг төсөл боловсруулах | 2021-2024 | 586.6 Улсын төсөв | Нэг маягийн зураг, давтан хэрэглэх зураг төслийг боловсруулж батлуулсан байна. | Сумын 10, 15, 22 ортой Эрүүл мэндийн төв, 50 ортой Хүүхдийн эмнэлгийн барилга байгууламжийн нэг маягийн болон давтан хэрэглэх зураг төслийг Нийслэлийн хот байгуулалтын хөгжлийн газраар 2021 онд баталгаажуулж, 21 аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. 30 | СЭЗГ-ХОХ<br>I-IV улирал | **100.0** |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв, 2021 он (сая төгрөг), Эх үүсвэр | 2021 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр | Хариуцах газар, хэлтэс | Үнэлгээ-ний хувь, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ажлыг зохион байгуулна | | | | ортой сүрьеэгийн эмнэлэг, Зоонозын өвчин судлалын төвийн барилгын нэг маягийн зураг, давтан хэрэглэх зураг төслийг боловсруулсан. | | |
| 32 | 2.1.4. Яаралтай тусламжийн чанар, үйлчилгээг олон улсын стандартад нийцүүлэн хөгжүүлнэ. | 2.Эрүүл мэндийн байгууллагуудын яаралтай тусламжийн чадавхыг сайжруулж, техник, тоног төхөөрөмжөөр хангана | 2021-2024 | 4,200.0 Улсын төсөв, Гадаадын зээл, тусламж | Лавлагаа шатлалын 6 эрүүл мэндийн байгууллагын яаралтай тусламжийн чадавх бэхэжсэн байна. | УНТЭ, УХТЭ, УГТЭ, ХӨСҮТ, ХСҮТ, ЭХЭМҮТ, ГССҮТ зэрэг 7 эрүүл мэндийн байгууллагад амьсгалын аппарат, яаралтай тусламжийн иж бүрдэл, унтуулгын аппарат, өвчтөний монитор, эрчимт эмчилгээний ор зэргийг Эрүүл мэндийн сайдын 2021 оныА/504, А/540, А/766 дугаар тушаалаар хуваарилж, яаралтай тусламжийн чадавхийг бэхжүүлсэн.<br>Эмнэлгийн түргэн тусламжийн туулах чадвар өндөртэй автомашин /яаралтай тусламжийн тоног төхөөрөмжтэй/, эмнэлгийн түргэн тусламжийн 30 автомашин /орон нутаг/ худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаж, хил, гаалийн асуудлаас болж автомашинууд нь БНХАУ-ын Тяньжин боомтод саатсан. | СЭЗГ-ХОХ, ЭТҮГ<br>I-IV улирал | **100.0** |
| 33 | | 3.Яаралтай тусламж, үйлчилгээнд агаарын үйлчилгээг /нисдэг тэрэг/ нэвтрүүлнэ | 2021-2022 | 11,200.0 Гадаадын зээл, тусламж | Нисдэг тэрэг худалдан авах бэлтгэл ажил хийгдсэн байна. | Азийн хөгжлийн банкны санхүүжилттэй Эрүүл мэндийн салбарын хөгжил-6 төслийн хүрээнд үндэсний түргэн тусламжийн тогтолцоог бэхжүүлэхэд агаарын түргэн тусламж нэвтрүүлэх арга хэмжээ тусгагдаж төслийн 1 дэх үе шат буюу 2025 онд агаарын яаралтай тусламж, үйлчилгээ (нисдэг тэрэг) нэвтрүүлэхээр төлөвлөсөн байна. Түргэн тусламжийн чадавхийг | СЭЗГ-ХОХ, ЭТҮГ<br>I-IV улирал | **30.0** |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв, 2021 он (сая төгрөг), Эх үүсвэр | 2021 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр | Хариуцах газар, хэлтэс | Үнэлгээ-ний хувь, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бэхжүүлэх чиглэлээр зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах олон улсын тендер зарлагдсан бөгөөд үнэлгээ хийгдэж байна. Олон улсын зөвлөх компанийн үйл ажиллагааны хүрээнд нисдэг тэргийг түргэн тусламж, үйлчилгээнд ашиглах хэрэгцээ шаардлагын судалгаа хийгдэж байна. Үүнтэй холбоотойгоор ГССҮТ, ЭХЭМҮТ-д нисдэг тэрэг буух талбайг байгуулсан. | | |
| 34 | | 4.Түргэн тусламжийн машины парк шинэчлэл хийнэ | 2021-2024 | 5,000.0 Улсын төсөв | 50 эрүүл мэндийн байгууллагад түргэн тусламжийн автомашин олгосон байна. | Баян-Өлгий аймгийн 5 сум (Өлгий, Цэнгэл, Улаанхус, Ногооннуур, Буянт сум) болон Өмнөговь аймгийн 11 сум (Баяндалай, Булган, Баян-Овоо, Манлай, Мандал-Овоо, Номгон, Ханхонгор, Ханбогд, Хүрмэн, Сэврэй, Цогт-Овоо), нийт 16 суманд 2021 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 724 сая төсөвт өртөг бүхий түргэн тусламжийн автомашиныг нийлүүлээд байна. Мөн Эмнэлгийн түргэн тусламжийн туулах чадвар өндөртэй автомашин /яаралтай тусламжийн тоног төхөөрөмжтэй/, Эмнэлгийн түргэн тусламжийн 30 автомашин /орон нутаг/ худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаж, хил, гаалийн асуудлаас болж автомашинууд нь БНХАУ-ын Тяньжин боомтод саатсан. НҮБ-ын Хүүхдийн сангаас АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн 221.0 сая төгрөгийн санхүүжилтээр нийт 5 | СЭЗГ- ХОХ<br>I-IV улирал | **90.0** |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв, 2021 он (сая төгрөг), Эх үүсвэр | 2021 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр | Хариуцах газар, хэлтэс | Үнэлгээ-ний хувь, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | аймгийн 9 сумын Эрүүл мэндийн төвд иж бүрэн тоноглосон эмнэлгийн автомашин хүлээлгэн өгсөн. Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар, Монгол Улсын Засгийн газар хоорондын нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээр сунгагдан батлагдсан бөгөөд уг төслийн хүрээнд “Орон нутагт явуулын эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх тусгай тоноглогдсон автомашин хангаж нийлүүлэх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг хуулийн хүрээнд зохион байгуулж Польш Улсын STOLARCZYK MIROSLAW TECHNOLOGIA POZARNICZA компанитай 2021 оны 07 дугаар сарын 23-ны өдөр гэрээ байгуулан ажиллаж байна. Гэрээний дагуу 2022 оны 04 дүгээр сард 32 автомашин нийлүүлэгдэнэ.<br>2021 оны жилийн эцсийн байдлаар 50 эрүүл мэндийн байгууллагад түргэн тусламжийн автомашин олгохоос 26 байгууллагад буюу 52 хувьд нь олгосон байна. 2022 оны 01 дүгээр сарын эхээр 30 автомашин хуваарилахад бэлэн болсон. | | |
| 35 | 2.1.5. Нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлж, хууль, эрх зүйн орчныг бий | 1.Төрөлжсөн мэргэшлийн төв болон аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгт эрүүл мэндийг дэмжих | 2021-2024 | 14,700.0 Улсын төсөв | 2 дүүрэг, 5 аймгийн нэгдсэн эмнэлэгт Эрүүл мэндийн дэмжих төв байгуулна | Хүн амыг өвчилсөн хойно нь бус өвдөхөөс өмнө нь урьдчилан сэргийлэх, өвчнийг эрт илрүүлэх тогтолцоо бүрдүүлэх зорилгоор Өвөрхангай, Ховд аймгийн БОЭТ, нийслэлийн Хан-Уул, Багануур | ЭТҮГ<br>I-IV улирал | **70.0** |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв, 2021 он (сая төгрөг), Эх үүсвэр | 2021 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр | Хариуцах газар, хэлтэс | Үнэлгээ-ний хувь, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | болгоно. | төв байгуулна | | | | дүүргийн Эрүүл мэндийн төвийн дэргэд “Эрүүл мэндийг дэмжих төв” байгуулж тоног төхөөрөмжөөр хангасан. Эрт илрүүлэг, үзлэг, шинжилгээнд зориулж 1.2 тэрбум төгрөгийн өртөг бүхий 20 гаруй төрлийн иж бүрэн тоног төхөөрөмжийг дагалдах хэрэгслийн хамт суурилуулсан. Мөн Архангай, Орхон, Дархан-Уул, Хөвсгөл, Баянхонгор, Говь-Алтай, Төв, Хэнтий, Дорноговь аймгийн Замын-Үүд зэрэг 9 аймаг, нийслэлийн Баянзүрх дүүрэгт шинээр “Эрүүл мэндийн дэмжих төв”-ийн бэлтгэл ажил хийгдсэн бөгөөд тоног төхөөрөмжүүдийг суурилуулж эхэлсэн. | | |
| 36 | | 2.Монгол Улсын хэмжээнд мөрдөх заавал хийх дархлаажуулал-тын үндэсний товлолыг шинэчлэн батлуулна | 2021-2023 | - Улсын төсөв | Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж батлуулна. | Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл, үзэл баримтлал боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, удирдамж, төлөвлөгөөг Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/736 дугаар тушаалаар байгуулсан. | НЭМГ- ХӨХ<br>III улирал | **30.0** |
| 37 | | 3.Эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа, ухуулга нөлөөлөл, тандалт судалгааны ажлыг зохион | 2021-2024 | 3,000.0 Гадаадын зээл, тусламж | Эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа, ухуулга нөлөөлөл, тандалт судалгааны ажлыг зохион байгуулна. | Эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа, ухуулга нөлөөлөл, тандалт судалгааны ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор 2021 онд Эрүүл мэндийг дэмжих сангаас нийт 3.0 тэрбум төгрөгийн төсөв зарцуулахаар төлөвлөгдсөн ба эрүүл мэндийг дэмжих төсөл, арга хэмжээг дараах | НЭМГ<br>I-IV улирал | **100.0** |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв, 2021 он (сая төгрөг), Эх үүсвэр | 2021 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр | Хариуцах газар, хэлтэс | Үнэлгээ-ний хувь, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | байгуулахад дэмжлэг үзүүлнэ | | | | байдлаар зохион байгуулсан. Үүнд: 2021 оны 1, 2 дугаар улиралд нийт 145 төслийн санал хүлээн авснаас 28 төслийг, 3 дугаар улиралд нийт 48 төслийн санал хүлээн авснаас 23 төслийг, 4 дүгээр улиралд нийт 115 төслийн санал хүлээн авснаас 30 төслийг сонгон шалгаруулж, нийт 2,963,632,883 төгрөгийн санхүүжилт олгож, хэрэгжилтэд хяналт тавин ажилласан. Эдгээр төсөлт ажлын хүрээнд эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, холбоо, нийгэмлэгүүд нь эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа, ухуулга нөлөөлөл, тандалт судалгааны ажлыг 2021 оны турш тасралтгүй зохион байгуулж амжилттай хэрэгжүүлж байна. | | |
| 38 | | 4.Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төслийг боловсруулж батлуулна | 2021-2023 | - | Хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл, хуулийн төслийг боловсруулсан байна. | Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/171 дүгээр тушаалаар Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулж, ажлын хэсгийн удирдамжийг батлуулсан. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн үзэл баримтлалын төслийг боловсруулан, 2021 оны 12 дугаар сарын 09-ний өдөр Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвтэй хамтран анхны хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Хэлэлцүүлгээс гарсан | НЭМГ<br><br>I-IV улирал | **50.0** |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв, 2021 он (сая төгрөг), Эх үүсвэр | 2021 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр | Хариуцах газар, хэлтэс | Үнэлгээ-ний хувь, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зөвлөмжийг хуулийн төсөлд тусгах ажил хийгдэж байна. | | |
| 39 | | 5.Нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэхэд шаардлагатай дүрэм, стандартуудыг шинэчлэнэ | 2021-2022 | - | Шаардлагатай дүрэм, стандартыг шинэчлэн батлуулсан байна. | Дорнод, Хэнтий, Сүхбаатар, Завхан, Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Увс, Баян-Өлгий, Ховд зэрэг 10 аймгийн төлөөллийг оролцуулан нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний стандарт, холбогдох дүрэм, журмын төслийн хэлэлцүүлэг уулзалт зохион байгуулсан ба стандартын төслийг ЭМЯ-ны Стандартчиллын хорооны хурлаар хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна. | НЭМГ<br><br>I-IV улирал | **30.0** |
| 40 | | 6.Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна | 2020-2024 | - | Хуулийн төслийг боловсруулсан байна. | Монгол Улсын Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийг ЦЕГ, ХЗДХЯ, СЯ, ГХЯ, ХХААХҮЯ, ТЕГ, ГЕГ, НЗАА, МХЕГ-ын төлөөллийг оролцуулан Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/75 дугаар тушаалаар байгуулсан. Ажлын хэсгийн уулзалтыг 2021 оны 05 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулсан бөгөөд уулзалтаас гарсан шийдвэрийн дагуу ажлын хэсгийн гишүүд 4 баг болон хуваагдаж Тамхины хяналтын тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн хуулийн төслийг боловсруулж байна. | НЭМГ-ХБӨХ<br><br>III-IV улирал | **50.0** |
| 41 | 2.1.6."Цахим Монгол" арга хэмжээний хүрээнд эрүүл мэндийн | 1.Салбарын түвшинд мэдээллийн технологийн сүлжээний дэд | 2021-2024 | 700.0 Улсын төсөв | 14 эрүүл мэндийн байгууллагад сүлжээний дэд бүтэц бий болсон байна. | 2021 онд нийт 48 эрүүл мэндийн байгууллагыг шилэн кабелийн VPN сүлжээний дэд бүтцэд холбон, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2 дугаар байранд төв зангилааг байршуулсан. | БТГ-СТХ<br><br>I-IV улирал | **100.0** |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв, 2021 он (сая төгрөг), Эх үүсвэр | 2021 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр | Хариуцах газар, хэлтэс | Үнэлгээ-ний хувь, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, орон нутагт хийгдэх оношилгоо, эмчилгээнд алсын зайн технологи ашиглан, цахим эрт илрүүлэг, эргэн дуудах тогтолцоог бүрдүүлнэ. | бүтцийг бий болгоно | | | | Тухайлбал, 21 аймгийн нэгдсэн эмнэлэг хөдөөгийн нэгдсэн эмнэлэг 4, БОЭТ 5, ЭМЯ-ны харьяа 9 эрүүл мэндийн байгууллага, дүүргийн эрүүл мэндийн төв 9, нийт 39 эрүүл мэндийн байгууллагыг “Юнител” ХХК-тай, Улаанбаатар хотын 9 эрүүл мэндийн байгууллагыг “Мобиком” ХХК-тай хамтран гүйцэтгэсэн. Энэхүү VPN сүлжээний аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор төвлөрсөн FIREWALL төхөөрөмж худалдан авах захиалга болон Тагнуулын ерөнхий газраас ирүүлсэн техникийн шаардлагыг Дэлхийн банкны “Цахим эрүүл мэнд” төслийн нэгжид хүргүүлсэн. | | |
| 42 | | 2.Эрүүл мэндийн байгууллагад мэдээлэл солилцооны платформ нэвтрүүлнэ. | 2021-2022 | 9,800.0 Гадаадын зээл, тусламж | Эрүүл мэндийн байгууллагын 50 хувьд нь Мэдээлэл солилцооны платформ нэвтэрсэн байна. | Эрүүл мэндийн байгууллагад мэдээлэл солилцооны платформыг Дэлхийн банкны “Цахим эрүүл мэнд” төслийн хүрээнд хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Мэдээлэл солилцооны платформын анхны туршилтыг УГТЭ, Увс аймгийн нэгдсэн эмнэлэг хооронд амжилттай туршсан. Тус төслийн хүрээнд эрүүл мэндийн өгөгдөл солилцооны нэгдсэн платформ хөгжүүлж, нэвтрүүлэх хүрээнд дараах ажлуудыг хийсэн. Үүнд:<br>- Эрүүл мэндийн өгөгдлийн тайлбар толь бичиг боловсруулах ажлыг эрчимжүүлж, эхлэлийн тайланг хүлээн авсан. | БТГ-СТХ I-IV улирал | **30.0** |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв, 2021 он (сая төгрөг), Эх үүсвэр | 2021 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр | Хариуцах газар, хэлтэс | Үнэлгээ-ний хувь, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Эрүүл мэндийн өгөгдөл, мэдээлэл технологийн стандарт боловсруулах ажлыг ЭМЯ-ны Стандартын дэд хорооны болон ТНБД-ын 2021 оны А/114 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлж, 100 хувь хүлээн авсан. Тус стандартыг https://fhir.gov.mn домайн хаяг болон Үндэсний дата төвд байршуулсан.<br>- Эрүүл мэндийн өгөгдөл солилцооны платформын хүрээнд хөгжүүлэгдсэн үйлчлүүлэгчийн болон эмчийн портал цахим системүүд бүрэн дууссан. Эрүүл мэндийн байгууллага хооронд үйлчлүүлэгчийг шилжүүлэх цахим шилжүүлгийн хэсэг бүрэн дуусаж, туршилт хийгдсэн.<br>- E-Health програм хангамжтай лабораторийн өгөгдөл солилцооны туршилтийг амжилттай хийсэн. | | |
| 43 | | 3.Дүрс архивлан хадгалах /PACS/ нэгдсэн тогтолцоог бүрдүүлнэ | 2021-2024 | 2,200.0 Гадаадын зээл, тусламж | Эрүүл мэндийн байгууллагын 50 хувьд нь Дүрс архивлан хадгалах систем ашиглагдаж эхэлсэн байна. | Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр санхүүжиж буй “Цахим эрүүл мэнд” төслийн хүрээнд нийлүүлэгдсэн дүрс архивлан хадгалах тоног төхөөрөмж EZO дэлгэцээр тоноглогдсон workstation, програм хангамжийн хуваарилалтыг Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалаар УНТЭ, УГТЭ, ГССҮТ, Хөвсгөл, Увс аймгийн нэгдсэн эмнэлэг, Үндэсний дата төвд хуваарилан суурилуулж үйл ажиллагааг жигдрүүлсэн. Үндэсний Дата төвд | БТГ-СТХ<br><br>I-IV улирал | **50.0** |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв, 2021 он (сая төгрөг), Эх үүсвэр | 2021 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр | Хариуцах газар, хэлтэс | Үнэлгээ-ний хувь, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | суурилуулагдсан төвлөрсөн PACS системд бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудыг холбох ажлыг Дэлхийн банкны дэмжлэгтэй “Цахим эрүүл мэнд” төсөл хэрэгжүүлэн ажиллаж байна. | | |
| 44 | | 4.Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудад алсын зайн анагаах ухаан (Телемедицин) ашиглах боломжийг бүрдүүлнэ | 2021-2023 | -<br>Улсын төсөв | Лавлагаа шатлалын 4 эрүүл мэндийн байгууллагад Телемедицин нэвтэрсэн байна. | Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагаас ЭХЭМҮТ, УНТЭ, УГТЭ-т телемедицин ашиглаж байна. Мөн Эрчимт эмчилгээний тасгуудын хооронд телемедициний сүлжээ байгуулах үйл ажиллагааны хүрээнд ГССҮТ, УНТЭ, УГТЭ, ЭХЭМҮТ, ХӨСҮТ, ЦТЭ зэрэг 6 эрүүл мэндийн байгууллагыг холбон, үйл ажиллагааг жигдрүүлсэн. Коронавируст халдварын үеийн эрчимт эмчилгээний зөвлөх багийг байгуулж орон зай, цаг хугацаанаас үл хамааран эрчимт эмчилгээний тусламж, үйлчилгээг цаг алдалгүй зохион байгуулах зорилгоор ЭМХТ-д сервер нь байрлах lifesize программын application-ийн ашиглах эрхийг 21 аймаг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын харьяа эмнэлгүүдэд худалдан авч ашиглах зааврын хамт хүргүүлсэн. Ингэснээр эрчимт эмчилгээний тасгийн ажилчид гар утас болон зөөврийн компьютер зэрэг төхөөрөмжүүдээс холбогдож зөвлөгөө, мэдээлэл авсан бичлэг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн серверт хадгалагддаг давуу талтай | БТГ-СТХ<br>I-IV улирал | **100.0** |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв, 2021 он (сая төгрөг), Эх үүсвэр | 2021 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр | Хариуцах газар, хэлтэс | Үнэлгээ-ний хувь, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | болсон. Мөн Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолоор телемедициний үйлчилгээг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх боломжтой болсон.<br>Эрүүл мэндийн салбарын цахим шилжилтийг эхлүүлснээр иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ илүү ойртож хүлээгдэл, чирэгдлийг бууруулсан. Тухайлбал, эмнэлэгт үзүүлэх цаг захиалгын үйлчилгээ, лабораторийн шинжилгээний хариу, эмнэлгийн магадлагаа, вакцины гэрчилгээ, вакцинжуулалтад хамрагдсан талаарх QR код, эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлт гэх мэт үйлчилгээг бүрэн цахимжуулж E-mongolia системээс авах боломжтой болсон. | | |
| 45 | | 5.Эрүүл мэндийн мэдээллийн үндэсний төв байгуулна | 2021-2024 | 1,200.0 Улсын төсөв (үйл ажиллагаан ы орлого) | Эрүүл мэндийн мэдээллийн үндэсний төв байгуулагдаж, үйл ажиллагаагаа эхлүүлсэн байна. | Эрүүл мэндийн яамнаас Эрүүл мэндийн мэдээлэл, технологийн төв байгуулах үндэслэл, төсөл, бүтэц орон тоо, төсвийн төлөвлөгөө, дүрэм, Засгийн газрын тогтоолын төсөл, хуралдааны танилцуулга боловсруулж, яамдуудаас санал авч өөрөөс хамаарах бэлтгэлийг бүрэн хийсэн боловч Засгийн газрын 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 283 дугаар тогтоолоор үндэсний хэмжээнд нэгдсэн “И-Монгол академи” улсын төсөвт үйлдвэрийн газар” байгуулахаар болсон тул ажил зогссон. | БТГ-СТХ<br><br>II улирал | **50.0** |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв, 2021 он (сая төгрөг), Эх үүсвэр | 2021 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр | Хариуцах газар, хэлтэс | Үнэлгээ-ний хувь, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 46 | | 6.Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлнэ | 2021-2022 | - | Тусгай зөвшөөрлийн мэдээллийн нэгдсэн сан бүрдсэн байна | Азийн хөгжлийн банкны “Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийг сайжруулах” төслийн хүрээнд эрүүл мэндийн байгууллагуудын тусгай зөвшөөрлийн нэгдсэн сан байгуулсан. Тусгай зөвшөөрөл нь 2020 онд сунгагдсан эмнэлгүүдийн мэдээллийг нэг бүрчлэн тулгалт хийж “Цахим эрүүл мэнд” төслийн гүйцэтгэгчид хүргүүлж, өгөгдлийн санг үүсгэсэн. Тусгай зөвшөөрлийн мэдээний сан бүрдүүлж буй licemed, tz.moh.gov.mn, e-mongolia болон нийслэлийн эрүүл мэндийн газрын нийт 4 програм хангамжийг уялдаа холбоотой хөгжүүлэх уулзалтуудыг зохион байгуулж, системийн процесс зураглалыг боловсруулсан. Тус зураглалын дагуу тусгай зөвшөөрөл олгох цахим системийг хөгжүүлж дууссан бөгөөд төрийн өгөгдөл солилцооны ХУР, нэвтрэлт танилтын ДАН системтэй холбох холболтын ажил хийгдэж байна. Тус системийг https://tzmoh.gov.mn домайн хаяг болон Үндэсний дата төвд байршуулан, тусгай зөвшөөрөл олгодог шинжээч нар болон ЭМЯ-ны хариуцсан мэргэжилтэнд хандах эрхийг өгсөн.<br>Нийслэлийн эрүүл мэндийн газраас олгодог тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааг цахимжуулж, E-mongolia системд хуулийн этгээдийн хандах | БТГ-СТХ<br><br>I-IV улирал | **100.0** |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв, 2021 он (сая төгрөг), Эх үүсвэр | 2021 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр | Хариуцах газар, хэлтэс | Үнэлгээ-ний хувь, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэсгийг бүрэн оруулсан. | | |
| 47 | | 7.Үзлэгийн цаг товлох үйлчилгээг нэвтрүүлнэ | 2020-2021 | - | Эрүүл мэндийн байгууллагуудаар үйлчлүүлэгч иргэдэд цаг захиалгын үйлчилгээг цахим хэлбэрээр олгох үйл ажиллагаа жигдэрсэн байна. | 1800-0119 тусгай утсаар үзлэгийн цаг авах үйлчилгээ нийслэлийн 9 дүүргийн Эрүүл мэндийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлгүүд, Говь-Алтай, Баянхонгор, Хөвсгөл, Өвөрхангай, Сүхбаатар, Ховд зэрэг 6 аймагт бүрэн нэвтэрсэн. Мөн төрийн үйлчилгээний нэгдсэн систем (E-Mongolia)-ээр дамжуулан 21 аймаг, 9 дүүргийн нэгдсэн эмнэлэг, ЭМЯ-ны харьяа 18 эмнэлэг болон нийслэлийн 136 өрхийн эрүүл мэндийн төвийн цагийг онлайнаар захиалах үйлчилгээг шинээр нэвтрүүлж, бүрэн ашиглалтад оруулсан. | БТГ-СТХ<br><br>I-IV улирал | **100.0** |
| 48 | | 8.Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдэд мобайл тусламж, үйлчилгээг нэвтрүүлнэ | 2021-2023 | 1,300.0 Улсын төсөв | Нийт 63 сум, өрхийн эрүүл мэндийн төвд мобайл тусламж, үйлчилгээ нэвтэрсэн байна. | 2021 онд нийт 63 сум, өрхийн эрүүл мэндийн төвд мобайл тусламж, үйлчилгээ нэвтэрсэн. Эрүүл мэндийн сайдын “Хөрөнгө хуваарилах тухай” 2021 оны А/209, А/211 дугаар тушаалаар ДЭМБ санхүүжилтээр Баян-Өлгий аймгийн 16, Увс аймгийн 16, Сэлэнгэ аймгийн 24, Баянхонгор аймгийн 2, Говьсүмбэр аймгийн 3, Налайх дүүргийн 2, нийт 63 өрх, сум, тосгоны Эрүүл мэндийн төвд мобайл технологийн 28 нэр төрлийн 1 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмжийг олгосон. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдэд мобайл тусламж, үйлчилгээг нэвтрүүлж байгаатай холбогдуулан хүний нөөцийг чадавхжуулах хүрээнд | ЭТҮГ<br><br>I-IV улирал | **100.0** |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв, 2021 он (сая төгрөг), Эх үүсвэр | 2021 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр | Хариуцах газар, хэлтэс | Үнэлгээ-ний хувь, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээнд мобайл технологийн хэрэглээг өргөжүүлэх талаар цахим сургалтыг 2021 оны 4, 5 дугаар сард зохион байгуулсан. Сургалтад Налайх дүүрэг, Говьсүмбэр, Сэлэнгэ, Баянхонгор аймгийн бүх өрх, сумын ЭМТ-ийн нийт 271 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдаж, мобайл технологийн аппарат тоног төхөөрөмжийг хэрхэн ашиглах арга, аргачлал, нэн шаардлагатай зарим тусламж, үйлчилгээний оношилгоо, эмчилгээний заавар, лавлагаа шатлалд өвчтөн шилжүүлэх заалтууд, эрт илрүүлгийн мэдээллийг VHS программд хэрхэн оруулах талаар суралцсан байна. Түүнчлэн Хөвсгөл, Архангай, Өмнөговь аймгийн анхан шатны эрүүл мэндийн бүх байгууллагын 210 эмч, мэргэжилтнүүдэд дээрх сургалтыг 2021 оны 10-11 дүгээр сард зохион байгуулсан. | | |
| 49 | 2.1.7. Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн оновчтой арга, хэлбэрийг нэвтрүүлж, эрүүл мэндийн даатгалын | 1.Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сан байгуулна | 2021-2024 | - Улсын төсөв (ЭМДС) | Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн санг даатгалын санхүүжилтийн 6 хувиар байгуулсан байна. | Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн хурлаар “Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сан байгуулах тухай” 02 дугаар тогтоол батлагдсан. Уг эрсдэлийн санг эрүүл мэндийн сангийн 2021 оны орлогын 8 хувьтай тэнцэх хэмжээгээр байгуулсан. Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн санг | СЭЗГ-СДХ II-III улирал | **100.0** |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв, 2021 он (сая төгрөг), Эх үүсвэр | 2021 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр | Хариуцах газар, хэлтэс | Үнэлгээ-ний хувь, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | тусламж, үйлчилгээний нэр, төрлийг нэмэгдүүлж, эрсдэлийн сан байгуулна. | | | | | 2022 оны төсөвт 40 тэрбум төгрөгөөр суулгаж батлуулсан. | | |
| 50 | 2.1.7. Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн оновчтой арга, хэлбэрийг нэвтрүүлж, эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний нэр, төрлийг нэмэгдүүлж, эрсдэлийн сан байгуулна. | 2.Төр хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад Улсын төсөв (ЭМДС)-гаас амбулатори, өдрийн эмчилгээ, оношилгоонд олгох санхүүжилтийн ялгааг арилгана | 2021-2024 | 73,000.0 Улсын төсөв (ЭМДС) | Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын 70 хувьд гэрээ байгуулж, олгосон байна. | Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа 241 хувийн хэвшлийн ортой эмнэлгийн 177 буюу 73 хувьтай нь ЭМДЕГ-аас гэрээ байгуулан ажиллаж байна. Мөн өдрийн эмчилгээний тусламж, үйлчилгээг зөвхөн төрийн эрүүл мэндийн байгууллагуудад үзүүлдэг байсныг ЭМДҮЗ-ийн 2021 оны 03 дугаар тогтоолоор өөрчилж, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад нээлттэй болгож, ижил тарифаар санхүүжүүлэх нөхцөл бүрдүүлсэн. Энэхүү зохицуулалтыг хэрэгжүүлэхийн тулд ЭМДСангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журмыг шинэчлэх шаардлагатай ба журмын төслийг ЭМДҮЗ-ийн 2021 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хурлаар хэлэлцүүлсэн. Журам батлагдсаны дараа төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад сонгон шалгаруулалт зарлах үйл ажиллагаа явагдана. | СЭЗГ-СДХ<br><br>I-IV улирал | **70.0** |
| 51 | | 4.Эмнэлгийн хагас бие даасан | 2020-2024 | 6,000.0 Улсын төсөв | Эмнэлгийн хагас бие даасан байдал | 1. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 15 дугаар | ТЗУГ | **70.0** |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв, 2021 он (сая төгрөг), Эх үүсвэр | 2021 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр | Хариуцах газар, хэлтэс | Үнэлгээ-ний хувь, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | байдлыг эрүүл мэндийн байгууллагуудад үе шаттай нэвтрүүлнэ | | | 10 эмнэлэгт хэрэгжиж эхэлсэн байна. | зүйлийн 15.29-д заасны дагуу “Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлийн олон нийтийн төлөөллийг сонгох журам”-ыг Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/565 дугаар тушаалаар шинэчлэн баталсан бөгөөд 2021 оны 3 дугаар сард захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 5120 дугаарт бүртгүүлсэн.<br>2. “Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн захирлыг сонгон шалгаруулах журам”-ыг шинэчлэн боловсруулж, ХЗДХЯ-аас ирүүлсэн дүгнэлтийг тусган Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/414 дүгээр тушаалаар баталж, 2021 оны 7 дугаар сард захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 5382 дугаарт бүртгүүлсэн.<br>3. Эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хамт олны төлөөллийн 3 гишүүн (эмч, сувилагч/тусгай мэргэжилтэн, бусад ажилтан)-ийг нэр дэвшүүлэх хамт олны хурлыг зохион байгуулах үйл ажиллагааг нэгдсэн зохицуулалтаар хангах зорилгоор “Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн хамт олны төлөөллийг нэр дэвшүүлэх хурлыг | I-IV улирал | |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв, 2021 он (сая төгрөг), Эх үүсвэр | 2021 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр | Хариуцах газар, хэлтэс | Үнэлгээ-ний хувь, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зохион байгуулах удирдамж"-ийг шинээр боловсруулж Эрүүл мэндийн сайд баталсан.<br>4. 2021 онд Гэмтэл, согог судлалын үндэсний төв, Хавдар судлалын үндэсний төв, Улсын хоёрдугаар төв эмнэлэг, Өвөрхангай аймаг дахь Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Увс, Хөвсгөл аймгийн нэгдсэн эмнэлэг, нийслэлийн Сонинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн олон нийтийн төлөөлөл, хамт олны төлөөлөл, өмчлөгчийн төлөөллүүдийг тус тус тодруулж, эмнэлгийн хагас бие даасан байдал дээрх эмнэлгүүдэд хэрэгжиж эхэлсэн.<br>Сэлэнгэ аймгийн нэгдсэн эмнэлгийн ТУЗ-ын бүрэлдэхүүнийг хууль, журамд нийцүүлэн шинэчлэн батламжлах асуудлыг тус аймгийн Засаг даргын Тамгын газар нь Эрүүл мэндийн яамнаас арга зүйн дэмжлэг авч хариуцан хийж байна. Бусад аймгийн Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлгүүдэд ТУЗ байгуулах асуудлаар Эрүүл мэндийн яамнаас чиглэл өгч, 2022 оны 01 дүгээр сараас эхлүүлэхээр бэлтгэлийг хангуулж байна. ЭМЯ-аас бүх төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн ТУЗ байгуулах үйл | | |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв, 2021 он (сая төгрөг), Эх үүсвэр | 2021 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр | Хариуцах газар, хэлтэс | Үнэлгээ-ний хувь, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажиллагааг нэгдсэн арга зүй, зохицуулалтаар ханган ажиллаж байна. | | |
| 52 | | 5.Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг эрүүл мэндийн байгууллагад нэвтрүүлнэ | 2021-2024 | 500.0 Улсын төсөв | Төрийн өмчийн эрүүл мэндийн бүх байгууллагад нэвтрүүлнэ. | Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэлийн хүрээнд ЭМДҮЗ-ийн 2021 оны "Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай" 03 дугаар тогтоолыг баталсан. Тогтоолыг Хууль зүй, дотоод хэргийн яам хянаж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2021 оны 5037 дугаарт бүртгэсэн. Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлж, төрийн өмчийн эрүүл мэндийн бүх байгууллагад нэвтрүүлсэн. Мөн хувийн 177 эмнэлэг, 42 сувиллын газартай гэрээ байгуулан ажиллаж тусламж, үйлчилгээний зардлыг гүйцэтгэлээр санхүүжүүлсэн. | СЭЗГ-СДХ<br><br>II-III улирал | **100.0** |
| 53 | | 6.Санхүүжилтийн гүйцэтгэл, удирдлагын хагас бие даасан байдалтай уялдуулан эрүүл мэндийн байгууллагуудын хөгжлийн төлөвлөлтийг хэрэгжүүлнэ | 2021-2024 | - | Эрүүл мэндийн байгууллагууд хөгжлийн төлөвлөлттэй болж хэрэгжүүлж эхэлсэн байна. | ЭМЯ-ны харьяа байгууллага, аймаг, нийслэлийн ЭМГ, нэгдсэн эмнэлэг, НЭМГ-ын харьяа бусад байгууллагын удирдах ажилтан, холбогдох албан тушаалтнуудыг оролцуулан “Байгууллагын стратеги төлөвлөгөө боловсруулах арга зүй” цахим сургалтыг ЭМЯ, ЭМХТ, УА хамтран 06 дугаар сард зохион байгуулсан. ЭМЯ-аас 4 дүгээр сард ЭМЯ-ны харьяа байгууллагуудад стратеги төлөвлөгөө боловсруулахад анхаарах ерөнхий | БТГ-СУХ<br><br>I-IV улирал | **0** |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв, 2021 он (сая төгрөг), Эх үүсвэр | 2021 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр | Хариуцах газар, хэлтэс | Үнэлгээ-ний хувь, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | чиглэлийг хүргүүлсэн. | | |
| 54 | | 7.Эрүүл мэндийн үндэсний тооцоо болон тусламж, үйлчилгээний тариф тогтооход ашиглах зорилгоор тусламж, үйлчилгээний өртгийн бүртгэлийн цахим тогтолцоог эрүүл мэндийн байгууллагуудад нэвтрүүлнэ | 2021-2024 | 500.0 Улсын төсөв (ЭМДС) | Эрүүл мэндийн байгууллагын 10 хувьд цахим бүртгэлийн тогтолцоо нэвтэрсэн байна. | Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 03 дугаар тогтоолын дагуу эрүүл мэндийн салбарт ашигладаг эмнэлзүйн 7 програм хангамжийн хөгжүүлэлтийг бүрэн хийлгэж, ЭМДЕГ-тай хамтран шалгаж, бодит цагийн горимд шилжүүлсэн (EHealth, Carte, Medsoft, Wings, EClinic, Posmed, Easy hospital). Эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээ бүхий төр, хувийн хэвшлийн нийт 120 гаруй эрүүл мэндийн байгууллага тусламж, үйлчилгээний мэдээллийг бодит цагийн горимоор илгээж эхлээд байна. Энэ нь нийт гэрээт байгууллагын 8 хувийг эзэлж байна. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай гэрээтэй хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд бүрэн бодит цаг хугацаанд үзүүлсэн тусламж, үйлчилгээний нэхэмжлэлийг 100% цахимаар илгээж байна. | БТГ-СТХ<br><br>I-IV улирал | **100.0** |
| 55 | 2.1.7. Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн оновчтой арга, хэлбэрийг нэвтрүүлж, эрүүл мэндийн даатгалын тусламж, | 8.ЭМДЕГ-ын бүтцийг оновчтой болгож, хүний нөөцийг чадавхижуулна | 2021-2024 | - | ЭМДЕГ-ын бүтцийг оновчтой болгож, хүний нөөцийг чадавхжуулж эхэлнэ. | Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2020 оны 17 дугаар тогтоолоор “Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын бүтцийг шинэчлэн баталсан. Уг тогтоолын дагуу 2021 оноос ЭМДЕГ-ын бүтэц, зохион байгуулалт шинэчлэгдэж 5 газар, 7 хэлтэстэй болж, 21 аймаг, Багануур, Налайх дүүргийн эрүүл мэндийн даатгалын тасгийг өргөжүүлэн “Эрүүл | БТГ-СУХ<br><br>I-IV улирал | **100.0** |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв, 2021 он (сая төгрөг), Эх үүсвэр | 2021 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр | Хариуцах газар, хэлтэс | Үнэлгээ-ний хувь, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | үйлчилгээний нэр, төрлийг нэмэгдүүлж, эрсдэлийн сан байгуулна. | | | | | мэндийн даатгалын хэлтэс" болгон үйл ажиллагааг өргөжүүлсэн. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын 2020 оны төсөв 5.1 тэрбум төгрөг байсан бол 2021 онд 14.1 тэрбум төгрөгөөр буюу өмнөх оноос 9 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн бүтэц, орон тоог шийдвэрлэж байна. | | |
| 56 | | 9.Төрөөс болон ЭМД-аас хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний өртөг, багц, төлбөрийн хэмжээг тогтоох, зардлын тооцооллыг хийнэ | 2021 | 200.0 Улсын төсөв (ЭМДС) | Төрөөс хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ бүрэн ЭМД-ын сан руу шилжсэн байна. | Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны "Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай" 03 дугаар тогтоолоор төр төлбөрийг нь хариуцах тусламж, үйлчилгээг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалттай нэгтгэх замаар "Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийн жагсаалт"-ыг шинэчлэн баталж, мөрдөж байна. Улсын төсвөөс санхүүжүүлж байсан халдварт өвчин, хавдар, жирэмслэлт, төрөлт, нярайн эмгэг, сэтгэцийн өвчин, мэдээгүйжүүлэг, эрчимт эмчилгээ, түргэн тусламж, хөнгөвчлөх, сэргээн засах эмчилгээ нь ЭМДҮЗ-ийн 03 дугаар тогтоолоор батлагдсан 563 оношийн хамааралтай бүлгийн жагсаалтад багтсан ба хамтын төлбөргүй байхаар зохицуулагдсан. | СЭЗГ-СДХ<br>I-IV улирал | **100.0** |
| 57 | | 10.Эрүүл мэндийн | 2021- | 2,000.0 | Эрүүл мэндийн | ЭМДҮЗ-ийн 2021 оны 03 дугаар | БТГ-СТХ | **100.0** |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв, 2021 он (сая төгрөг), Эх үүсвэр | 2021 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр | Хариуцах газар, хэлтэс | Үнэлгээ-ний хувь, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | даатгалыг цахимжуулна | 2024 | Улсын төсөв (ЭМДС), Гадаадын зээл, тусламж | даатгалын цахим тогтолцоог бий болгож, бүх шатны эрүүл мэндийн байгууллагыг холбоно. | тогтоолын дагуу эрүүл мэндийн салбарт ашигладаг эмнэлзүйн 7 програм хангамжийн хөгжүүлэлтийг бүрэн хийлгэж, ЭМДЕГ-тай хамтран шалгаж, бодит цагийн горимд шилжүүлсэн (EHealth, Carte, Medsoft, Wings, EClinic, Posmed, Easy hospital). ЭМДЕГ-тай гэрээт улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд бүрэн бодит цаг хугацаанд үзүүлсэн тусламж үйлчилгээнийхээ нэхэмжлэлийг 100% цахимаар илгээж байна. | I-II улирал | |
| 58 | | 11.Төрөөс хариуцах иргэдийн шимтгэл, албан бус салбарын даатгуулагчдын хамрагдалт, шимтгэлийн хэмжээг өсгөх замаар Улсын төсөв (ЭМДС)-гийн орлогыг нэмэгдүүлнэ | 2021-2024 | - Улсын төсөв (ЭМДС) | Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ нэмэгдсэн байна. | Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаанаар Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг өмнөх онтой хэвээр тогтоож Засгийн газрын 2021 оны 408 дугаар тогтоолоор баталсан. Коронавируст халдвар, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан хувь хэмжээг нэмээгүй. | БТГ-СУХ<br><br>I-IV улирал | **30.0** |
| 59 | | 12.Олон улсын эмнэл зүйн удирдамжийн цахим санг нэвтрүүлнэ | 2021-2024 | 1,150.0 Улсын төсөв, Гадаадын зээл, тусламж | Олон улсын эмнэл зүйн удирдамжийг нэвтрүүлсэн байна. | Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2020 оны 20 дугаар тогтоолоор олон улсын эмнэл зүйн удирдамжийн цахим платформ “UpToDate”-ыг эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны төсвөөс гэрээ шууд байгуулах аргаар худалдан | ЭТҮГ, СЭЗГ-СДХ, БТГ-СТХ<br><br>I улирал | **100.0** |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв, 2021 он (сая төгрөг), Эх үүсвэр | 2021 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр | Хариуцах газар, хэлтэс | Үнэлгээ-ний хувь, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | авах шийдвэр гарсан. Цахим платформ ашиглах сургалтад аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагаас давхардсан тоогоор 8,000 гаруй эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан. Мөн UpToDate платформыг эзэмшдэг WoltersKluwer компанитай хамтран аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн, Чанарын албаны ажилтнуудыг хамруулан сургагч багш бэлтгэх 2 удаагийн сургалт зохион байгуулсан. Бэлтгэгдсэн 60 сургагч багшаар дамжуулж УНТЭ, УГТЭ, ХСҮТ, ГССҮТ, ЭХЭМҮТ зэрэг 5 байгууллагад сургалт зохион байгуулсан. 2021 оны жилийн эцсийн байдлаар 30,624 эрүүл мэндийн ажилтны бүртгэл үүсч, UpToDate платформыг ашиглаж байна. | | |
| 60 | 2.1.8.Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангаж, хүртээмжийг нэмэгдүүлэн бүртгэл, хяналтын цахим тогтолцоог бүрдүүлнэ. | 1.Эмийн аюулгүй байдлын цахим бүртгэл хяналтыг нэвтрүүлнэ | 2021-2024 | | Эмийн аюулгүй байдлын цахим бүртгэл хяналтыг эм ханган нийлүүлэх байгууллагын 50 хувьд нэвтрүүлсэн байна. | Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого, Эрүүл мэндийн сайдын 2013 оны 415, 145, 2016 оны А/232, 2017 оны А/407, 2018 оны А/64, 2019 оны А/295 дугаар тушаалын хүрээнд эмийн аюулгүй байдлын цахим бүртгэл хяналтыг нэвтрүүлэн ажиллаж байна. Азийн хөгжлийн банкны “Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийг сайжруулах” төслийн хүрээнд Эмийн аюулгүй байдлын цахим бүртгэлийг эрүүл мэндийн байгууллагуудын тусгай зөвшөөрлийн нэгдсэн сан байгуулах ажилтай хамтатган хэрэгжүүлсэн. | БТГ-СТХ<br>I-IV улирал | **100.0** |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв, 2021 он (сая төгрөг), Эх үүсвэр | 2021 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр | Хариуцах газар, хэлтэс | Үнэлгээ-ний хувь, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллага, эмийн үйлдвэр, эм ханган нийлүүлэх байгууллага, гадаадын эмийн үйлдвэрийн төлөөлөгчийн газрууд www.licemed.mohs.mn домайн хаягаар, иргэд, олон нийт www.druginfo.mohs.mn домайн хаягаар хандан ашигладаг ба нээлттэй мэдээлэл бүрэн байршсан. Тус системд эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн мэдээлэл, эм, эмийн түүхий эд, био идэвхт бодис, оношлуурын бүртгэлийн мэдээлэл, импорт, экспортын лиценз олгох үйл ажиллагаа, ханган нийлүүлэх байгууллага, үйлдвэрийн тайлан, эмийн гаж нөлөөний мэдээллийг бүрэн агуулдаг.<br>Эрүүл мэндийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвүүд тус системийг ашиглан мэдээлэл солилцож хэвшсэн.<br>Мөн тус зорилтын хүрээнд эмийн үнийн хөнгөлөлт олгох www.health.gov.mn цахим системийг хөгжүүлж бүрэн ашиглалтад оруулсан. Эмч, эмийн сан хороонд бодит цаг хугацаанд цахим эмийн жор бүртгэгдэж, иргэдэд | | |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв, 2021 он (сая төгрөг), Эх үүсвэр | 2021 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр | Хариуцах газар, хэлтэс | Үнэлгээ-ний хувь, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | олгогдож байна. Монгол Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг бүх эмийн сан хамрагдсан. | | |
| 61 | | 4.Нянгийн тэсвэржилтийн хяналтын дэлхийн сүлжээнд нэгдэж, нянгийн эсрэг эмийн зохистой хэрэглээг хянах тогтолцоог бүрдүүлнэ | 2021-2024 | 500.0 Гадаадын зээл, тусламж | Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд сүлжээнд нэгдэж, нянгийн тэсвэржилтийн талаарх мэдээллээ өгч хэвшсэн байна. | Нян судлалын антибиотик мэдрэг чанарын шинжилгээнд дүн шинжилгээ хийж, нянгийн тэсвэржилтийн тандалтын дэлхийн сүлжээ (WHONET GLASS)-д орох, мэдээллийг цуглуулах, эргэн мэдээлэх үйл ажиллагааг хэвшүүлэх зорилгоор WHONET-ийн программд эрүүл мэндийн байгуулагуудыг холбохоор ажиллаж байна. Одоогийн байдлаар дараах эрүүл мэндийн байгууллагууд холбогдон тогтмол мэдээлэл өгч хэвшээд байна. Үүнд: УНТЭ, УХТЭ, УГТЭ, ХСҮТ, ЭХЭМҮТ, АӨСҮТ, Баянзүрх, Баянгол, Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй, Налайх дүүргийн ЭМТ, Өргөө, Амгалан амаржих газар, УБ төмөр замын нэгдсэн эмнэлэг, Орхон, Төв, Ховд, Завхан, Баян-Өлгий, Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн нэгдсэн эмнэлэг, нийт 23 эрүүл мэндийн байгууллага хамрагдсан байна. | ЭТҮГ<br><br>I-IV улирал | **70.0** |
| 62 | 2.1.8.Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангаж, хүртээмжийг | 5.Эмийн зохицуулалтын төрийн захиргааны байгууллага байгуулна. | 2021-2024 | 3,800.0 Улсын төсөв | Эмийн зохицуулалтын төрийн захиргааны байгууллага байгуулагдсан байна. | Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 222 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын орон тооны дээд хязгаарыг 80 байхаар баталсан. ЭЭХХЗГ нь 7 газар (Лиценз, | ТЗУГ<br><br>I улирал | **100.0** |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв, 2021 он (сая төгрөг), Эх үүсвэр | 2021 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр | Хариуцах газар, хэлтэс | Үнэлгээ-ний хувь, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | нэмэгдүүлэн бүртгэл, хяналтын цахим тогтолцоог бүрдүүлнэ. | | | | | зөвшөөрлийн зохицуулалтын газар, Эмийн аюулгүй байдлын тандалт, судалгааны газар, Чанарын хяналтын газар, Эм шинжлэх лаборатори, Захиргаа, удирдлагын газар, Эм хангамжийн газар, Эмнэлгийн тоног төхөөрөмжийн газар) болон Эмийн бүртгэлийн болон Эм үйлдвэрлэлийн хэлтэстэй үйл ажиллагаагаа явуулж байна. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 378 дугаар тогтоолоор Мэргэжлийн хяналтын төв болон орон нутгийн байгууллагын 28, Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн Эмийн хяналтын лабораторийн 24, нийт 52 албан хаагчийг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газарт орон тоо, цалингийн сан, холбогдох зардлын хамт 2021 оноор тасалбар болгон шилжүүлэх арга хэмжээ авахыг Шадар сайд, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайд нарт даалгасны дагуу Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын орон тоог 132 болгон нэмэгдүүлсэн. | | |
| 63 | | 6.Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд тэргүүлэх чиглэлийг үндэслэн | 2021-2024 | | Эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэлийн дотоодын зах зээлд эзлэх хувь 0.6 болсон байна. | Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд коронавируст халдварын цар тахлын үед эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэлийг төрөөс бодлогоор дэмжиж ажилласан. Монгол Улсын хэмжээнд 38 үйлдвэр эм, эмнэлгийн | БТГ-СУХ<br><br>I-IV улирал | **100.0** |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв, 2021 он (сая төгрөг), Эх үүсвэр | 2021 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр | Хариуцах газар, хэлтэс | Үнэлгээ-ний хувь, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэлийг бодлогоор дэмжинэ | | | | хэрэгсэл, БИБ, ариутгал халдваргүйтгэлийн бодис үйлдвэрлэх үйл ажиллагаа явуулж, 17 нэрийн эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэж байна. Эдгээр үйлдвэрүүдийг дэмжих зорилгоор дараах арга хэмжээг 2021 онд авсан. Үүнд:<br>- “Гранд Эко Эхлэл” ХХК -д эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл олгосон<br>- БНХАУ-ын Эрээн боомт түр хугацаагаар хаагдсан, Тяньжин боомтод ачаа саатсантай холбоотой БНХАУлс, БНСУлаас агаарын тээврээр дотоодын үйлдвэрүүдийн саатсан 65.4 тонн эм, эмнэлгийн хэрэгслийн түүхий эд, туслах материалыг хөнгөлөлттэй үнээр татан авах үйл ажиллагааг зохион байгуулснаар үйлдвэрлэл хэвийн явагдах боломжтой болсон<br>- Дотоодын 5 үйлдвэрлэгч 2021 онд 22,0 тэрбум төгрөгийн эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэсэн нь эмнэлгийн хэрэгслийн дотоодын зах зээлийн 12 хувийг эзэлж байна. | | |
| 64 | | 7.Биобэлдмэлийн үйлдвэрлэлийг эрчимжүүлнэ | 2021-2024 | 1,000.0 Улсын төсөв | Биобэлдмэл, тэжээлт орчны үйлдвэрлэл 20 хувиар өссөн байна. | 2010 оноос үйл ажиллагаа нь зогсоод байсан “Биобэлдмэлийн үйлдвэр”-ийн үйл ажиллагааг сэргээсэн. Биобэлдмэлийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 144 дүгээр тогтоолоор 284,0 сая төгрөг, Эрүүл мэндийн сайдын багцаас Биобэлдмэлийн | БТГ-СУХ<br><br>I-IV улирал | **70.0** |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв, 2021 он (сая төгрөг), Эх үүсвэр | 2021 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр | Хариуцах газар, хэлтэс | Үнэлгээ-ний хувь, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үйлдвэрт шаардлагатай тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтад 3 тэрбум төгрөг тус тус төсөвлөгдсөн. Үйлдвэрийн чанарын хяналтын лабораторид шаардлагатай 9 төрлийн тэжээлт орчныг технологийн зааврын дагуу бэлтгэж, Чанарын хяналтын албанд хэрэглэж байна. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвд 2021 онд тэжээлт орчны үйлдвэрлэл 5 хувиар өссөн. Зоонозын өвчин судлалын үндэсний төвд 2021 онд тэжээлт орчны үйлдвэрлэл нэмэгдсэн. | | |
| 65 | | 9.Эмнэлгийн тоног төхөөрөмжийн чанар аюулгүй байдал, бүртгэл, засвар үйлчилгээний тогтолцоог бэхжүүлнэ | 2021-2024 | - Улсын төсөв | Эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийн сан бүрэн нэвтрүүлж, шалгалт тохируулгын тогтолцоог өргөжүүлсэн байна. | Эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт тохируулгын үйл ажиллагаа 2021 оны 08 дугаар сарын 03 өдрөөс эхэлсэн бөгөөд 2021 оны жилийн эцсийн байдлаар нийт 73 эрүүл мэндийн байгууллагын 13 нэр төрлийн 873 эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийхэд 88.8 хувь эмнэлгийн тоног төхөөрөмж шалгалт тохируулгад тэнцсэн байна. “Эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийн сан”-гийн цахим програм /www.heps.hdc.gov.mn/-ын бүртгэлийн хяналтыг 57 байгууллагад хийсэн. 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар тус цахим програмд 598 эрүүл мэндийн байгууллагын 996 хэрэглэгч, 23,894 эмнэлгийн тоног төхөөрөмж бүртгэгдсэн байна. | ЭТҮГ I-IV улирал | **100.0** |
| 66 | 2.1.9. Эрүүл | 1.Эмнэлгийн | 2021- | 250.0 | 2 БОЭТ төгсөлтийн | Эрүүл мэндийн яамны дэргэдэх | БТГ-СУХ | **70.0** |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв, 2021 он (сая төгрөг), Эх үүсвэр | 2021 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр | Хариуцах газар, хэлтэс | Үнэлгээ-ний хувь, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | мэндийн ажилтны эрх зүйн шинэчлэл хийж, хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлж, нийгмийн хамгааллыг дэмжинэ. | мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын сүлжээг Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд бий болгон, чадавх бэхжүүлнэ | 2024 | Улсын төсөв | дараах сургалт явуулдаг болно. | Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн 2021 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн анхдугаар хурлаар сургалт эрхлэх үйл ажиллагааг өргөжүүлэх хүрээнд “Ерөнхий мэргэшил судлал” үндсэн мэргэшлийн чиглэлээр Бүсийн оношилгоо, эмчилгээний төвүүдэд сургалт эрхлэх байгууллагын зөвшөөрөл олгох, сувилахуйн мэргэшүүлэх сургалт эрхлэх зөвшөөрөл олгох асуудлыг хэлэлцсэн. Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын сүлжээг Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд байгуулах хүрээнд Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн 12 дугаар сарын 01-ний өдрийн хурлаар Орхон аймаг дахь БОЭТ-д Эрчимт эмчилгээний сувилахуй, Яаралтай тусламжийн сувилахуй чиглэлээр төгсөлтийн дараах сургалт эрхлэх зөвшөөрөл олгосон.<br>Өвөрхангай аймаг дахь БОЭТ-д Эрүүл мэндийн сайдын 2017 оны “Журам шинэчлэн батлах тухай” А/337 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан журамд заасан сургалт эрхлэх байгууллагад тавигдах шаардлагын дагуу үнэлгээ хийж, “Ерөнхий мэргэшил судлал” үндсэн мэргэшлийн сургалт эрхлэх зөвшөөрөл олгох үнэлгээний тайланг Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн | I-IV улирал | |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв, 2021 он (сая төгрөг), Эх үүсвэр | 2021 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр | Хариуцах газар, хэлтэс | Үнэлгээ-ний хувь, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хурлаар хэлэлцүүлэхэд бэлэн болгоод байна. | | |
| 67 | | 2.Анагаахын шинжлэх ухаан, технологийн дэвшил, инновацын тэргүүлэх чиглэлээр эмнэлгийн мэргэжилтэнг гадаадад урт хугацааны сургалтад хамруулна | 2020 - 2024 | 300.0 Улсын төсөв | Эмнэлзүйн чиглэлээр 5 эмнэлгийн мэргэжилтэнг гадаад улсад урт хугацаагаар суралцуулсан байна. | 2021 онд дараах чиглэлээр эмнэлгийн мэргэжилтнүүд гадаад улсад сургалтад хамрагдсан: Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Нэгдсэн лабораторийн албаны вирус судлалын лабораторийн тасгийн 2 их эмч, 1 био-анагаах судлаач нар Япон Улсад “SARS COVID” бүрэн генийн дараалалыг тодорхойлох сургалтад, Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн Хүүхдийн гэмтэл согогийн тасгийн 1 их эмч Турк Улсад хүүхдийн гэмтлийн мэргэжил дээшлүүлэх сургалтад тус тус хамрагдсан. | БТГ-СУХ I-IV улирал | **90.0** |
| 68 | | 3.Эмнэлгийн мэргэжилтний ажиллан суралцах арга хэмжээг хэрэгжүүлнэ | 2021-2024 | Улсын төсөв | 50 хүртэлх эмч, мэргэжилтэн ажиллан суралцсан байна. | 2021 онд эмнэлгийн мэргэжилтнүүд дараах чиглэлээр ажиллан суралцах арга хэмжээнд хамрагдсан: - Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах, орон нутгийн лабораторийн хүчин чадлыг сайжруулах зорилгоор ПГУ-ын молекул биологийн лаборатори шинээр байгуулах, ажиллах хүний нөөц эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг ажиллан суралцах журмын дагуу зохион байгуулж энэхүү үйл ажиллагааны хүрээнд орон нутгаас 32, нийслэлээс 32, нийт 64 эмч, мэргэжилтнийг ажиллан суралцах журмаар 2021 оны | БТГ, ЭТҮГ I-IV улирал | **100.0** |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв, 2021 он (сая төгрөг), Эх үүсвэр | 2021 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр | Хариуцах газар, хэлтэс | Үнэлгээ-ний хувь, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2-3 дугаар сард 1 сарын хугацаагаар сургалтад хамруулсан.<br>- ЭМЯ-ны дэргэдэх Яаралтай тусламж судлал, Эрчимт эмчилгээ судлал, Мэдээгүйжүүлэг судлалын мэргэжлийн салбар зөвлөлтэй хамтран 21 аймгийн яаралтай тусламж, эрчимт эмчилгээ, мэдээгүйжүүлэг судлалын эмч, сувилагч нарын бүсчилсэн сургалтыг Орхон, Завхан, Өвөрхангай, Дорноговь, Дорнод аймгуудад зохион байгуулж, 60 эмч, 60 сувилагчийг ажлын байран дээр нь сургаж дадлагажуулсан. | | |
| 69 | 2.1.9. Эрүүл мэндийн ажилтны эрх зүйн шинэчлэл хийж, хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлж, нийгмийн хамгааллыг дэмжинэ. | 5.Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын хөтөлбөр хэрэгжүүлнэ | 2021-2023 | -<br>Улсын төсөв | Хөтөлбөрийн үйл ажиллагаа хэрэгжилт 40 хувь байна. | Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 193 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн хүрээнд “Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежмент: КОВИД-19 цар тахлын үед аюулгүй ажиллах ерөнхий зааварчилгаа MNS ISO/PAS 45005:2021” стандартыг батлуулж, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдэд хүргүүлсэн. Төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын нийт 117,674 ажилтныг коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад хамруулсан. Хөтөлбөрийн хэрэгжилт 58.3 хувьтай байна. | БТГ-СУХ<br>I-IV улирал | **100.0** |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв, 2021 он (сая төгрөг), Эх үүсвэр | 2021 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр | Хариуцах газар, хэлтэс | Үнэлгээ-ний хувь, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 70 | | 6.Сувилахуйн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төсөл хэрэгжүүлнэ | 2021-2024 | 500.0 Гадаадын зээл, тусламж | Сургалтыг удирдах сувилагч-сургагч багш 100-аас доошгүй бэлтгэгдсэн байна. | “Төгсөлтийн дараах сургалт удирдах “Сувилахуйн чиглүүлэгч багш”, “Сувилахуйн сургагч багш” бэлтгэх сургалт зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, удирдамжийг Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/488 дугаар тушаалаар батлуулсан. ЖАЙКА-тай хамтарсан тус ажлын хэсэг нийт 7 удаа хуралдаж, “Монголын сувилахуйн мөн чанар-Монголын сувилахуйн ирээдүй” сургалт семинарыг 2021 оны 9 дүгээр сарын 23-24-ний өдрүүдэд, “Сувилахуйн сургагч, чиглүүлэгч багшийн хөтөлбөр шинэчлэх” семинарыг 2021 оны 11 дүгээр сарын 08-10-ны өдрүүдэд тус тус зохион байгуулсан ба сувилахуйн сургагч багшийн сургалтыг 2021 оны 11 дүгээр сарын 23-25-ны өдрүүдэд зохион байгуулж, 46 сувилахуйн сургагч багш бэлтгэсэн. Чиглүүлэгч багшийн сургалтыг 2021 оны 12 дугаар 23-25-ны өдөр зохион байгуулж, 24 чиглүүлэгч багш бэлтгэгдсэн. 2021 оны 12 дугаар 28-29-ны өдөр зохион байгуулах байсан Сувилахуйн сургагч багшийн сургалтыг КОВИД-19-ын улмаас хойшлуулж, 2022 оны 01 дүгээр сарын эхээр зохион байгуулахаар төлөвлөж байна. | ТЗУГ-СТХ<br><br>I-IV улирал | **70.0** |
| 71 | | 7.Төгсөлтийн дараах гадаад сургалтын 2021- | 2021-2024 | 600.0 Гадаадын зээл, | Гадаад сургалтын чиглэл батлагдаж, 100-аас доошгүй | 2022-2024 оны гадаад сургалтын тэргүүлэх чиглэлийг батлах Эрүүл мэндийн сайдын тушаалын төсөл | БТГ-СУХ<br><br>I-IV улирал | **30.0** |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв, 2021 он (сая төгрөг), Эх үүсвэр | 2021 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр | Хариуцах газар, хэлтэс | Үнэлгээний хувь, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2024 оны чиглэлийг батлан хэрэгжүүлнэ | | тусламж | эмнэлгийн мэргэжилтэн богино хугацааны гадаад сургалтанд хамрагдсан байна. | боловсруулж, санал авч байна. Хүйн цусны банк байгуулах чиглэлээр БНТУ-ын Истанбул хотын Медикал группын Медикал парк эмнэлэгт ЭМЯ, ЭМХТ, УНТЭ, ЦССҮТ, Өргөө амаржих газрын удирдах албан хаагч, эмч, эмнэлгийн мэргэжилтэн нийт 10 хүн 7 хоногийн сургалтад хамрагдсан. | | |
| 72 | 2.1.10. Үйлчлүүлэгч, эмчлүүлэгчийн эрүүл мэндийн эрхийг хамгаалах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ. | 1.Эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсрууулж, батлуулна | 2021-2022 | - | Хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулж, батлуулна. | Эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах зорилгоор Хууль тогтоомжийн тухай хуулийн .13 дугаар зүйлд заасны дагуу хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах үйл ажиллагааг эхлүүлээд байна. Хуульд орсон нэмэлт өөрчлөлт бүрийн хуулийн төслийн үзэл баримтлалд дүн шинжилгээ хийх, хуулийн зүйл заалтыг бусад хэрэгжиж байгаа болон шинээр боловсрогдож байгаа хуулийн зүйл заалттай уялдуулах зэрэг үйл ажиллагааг хийж байна. Монгол Улсын Их Хурлын 2022 оны хаврын чуулганы хуралдаанаар Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл хэлэлцүүлэхээр төлөвлөж байна. | БТГ-СУХ<br>IV улирал | **30.0** |
| 73 | 2.1.11. Бүсийн эмнэлэг, оношилгооны төвийг үе шаттайгаар байгуулна. | 1.Барилга байгууламжийг барьж, тоног төхөөрөмжөөр хангах, хүний нөөцийг | 2021-2024 | 3,000.0 Улсын төсөв | Бүсийн эмнэлэг, оношилгооны төвийг үе шаттайгаар байгуулна. | Ховд аймгийн БОЭТ-ийн барилгын ажлын даалгаврыг боловсруулан дуусгасан. Барилгын зураг төслийг боловсруулсан. Барилгын ажлын санхүүжилт шийдвэрлэгдээгүй байна. “Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 | СЭЗГ-ХОХ<br>I-IV улирал | **70.0** |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв, 2021 он (сая төгрөг), Эх үүсвэр | 2021 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр | Хариуцах газар, хэлтэс | Үнэлгээ-ний хувь, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | бүрдүүлнэ | | | | оны “Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө”-нд Дорнод аймгийн БОЭТ-ийн Хүүхдийн эмнэлгийн 200 ортой эмнэлэг барих 2.0 тэрбум төгрөгийн төсөв суусан бөгөөд худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаж “Ихбазар констракшн” ХХК-тай гэрээ байгуулж, барилга угсралтын ажил 40.0%-тай байна.<br>Мөн Өмнөговь аймгийн Даланзадгад сумын Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд нийлүүлэгдэх рентген аппаратаар тоноглогдсон эмнэлгийн автомашины худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаж “Сүвэн Уул” ХХК-тай гэрээ байгуулсан боловч автомашин БНХАУ-ын Тяньжин боомтод саатсан.<br>2021 онд Өмнөговь, Орхон, Ховд, Дорнод, Өвөрхангай зэрэг 5 аймгийн БОЭТ-д 6.9 тэрбум төгрөгийн 64 зүслэгтэй компьютер томографийн аппарат, 8.9 тэрбум төгрөгийн ангиографийн тоног төхөөрөмж ханган нийлүүлсэн. | | |
| 74 | 2.1.12. Аймаг, сумын эрүүл мэндийн байгууллага, эмнэлгүүдийн барилга байгууламж, дэд бүтцийг | 1.Аймаг, сумын эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламж, дэд бүтцийн засвар шинэчлэлтийн ажил хийнэ | 2021-2024 | 8,750.0 Улсын төсөв | Тэгш хүртээмжтэй, чанартай үйлчилгээг үзүүлэх орчныг бүрдүүлнэ. | Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуульд тусгагдсан 31.9 тэрбум төгрөгийн 21 барилгын зураг төсвийг бүрэн боловсруулан Барилгын хөгжлийн төвийн магадлалаар баталгаажуулан, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлсэн бөгөөд худалдан авах | СЭЗГ-ХОХ<br>I-IV улирал | **90.0** |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв, 2021 он (сая төгрөг), Эх үүсвэр | 2021 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр | Хариуцах газар, хэлтэс | Үнэлгээ-ний хувь, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | сайжруулан стандарт, чанарын шаардлага хангасан тэгш хүртээмжтэй, чанартай үйлчилгээг үзүүлэх орчныг бүрдүүлнэ. | | | | | ажиллагаа зохион байгуулагдаж 19 барилгын гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж, барилга угсралтын ажил эхлээд байна.<br>Эрүүл мэндийн салбарын хэмжээнд шинээр хэрэгжүүлэхээр нийт 8.8 тэрбум төрөгийн 32 их засварын төсөл, арга хэмжээ батлагдсанаас 27 төсөл, арга хэмжээний гэрээ байгуулсан бөгөөд засварын ажлын гүйцэтгэл 80 хувьтай, 5 төсөл, арга хэмжээ худалдан авах ажиллагаа зарлагдсан. | | |
| 75 | | 2.Ундны ус, ариун цэврийн байгууламжийн аюулгүй байдлын төлөвлөгөөг боловсруулж, улсын хэмжээнд хэрэгжүүлнэ | 2021-2024 | 27.0 Гадаадын зээл, тусламж | 2 аймагт аудит, 4 жижиг суурин газарт УАБТ-г боловсруулах, УАБТ-ний хэрэгжилт 50 хувиас доош байгаа 2 хангагч байгууллагад талбарын сургалт, усны чанар, аюулгүй байдалд эрсдэлийн үнэлгээ хийсэн байна. | Усны аюулгүй байдлын төлөвлөгөөний хэрэгжилт хангалтгүй орон нутаг болон нийслэлийн байгууллагад хөндлөнгийн аудит хийж зөвлөмж хүргүүлэн ажилласан. Үүнд:<br>- “Дорноговь аймагт 2021 оны 08 дугаар сарын 09-13-ны өдрүүдэд ус хангагч байгууллагад хэрэгжиж буй усны аюулгүй байдлын төлөвлөгөөнд хөндлөнгийн аудит хийх зохион байгуулж ажилласан ба тайлан, зөвлөмжийг 1а/4880 албан тоотоор аймгийн ЗДТГ-т хүргүүлсэн.<br>- Улаанбаатар хотын Ус сувгийн удирдах газарт 2021 оны 07 дугаар сарын 19-23-ны өдрүүдэд усны аюулгүй байдлын төлөвлөгөөнд хөндлөнгийн аудит хийж тайлан зөвлөмжийг 2/4827 албан тоотоор Ус сувгийн удирдах газарт | НЭМГ<br><br>III улирал | **100.0** |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв, 2021 он (сая төгрөг), Эх үүсвэр | 2021 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр | Хариуцах газар, хэлтэс | Үнэлгээ-ний хувь, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүргүүлсэн.<br>- Нийслэлийн хүн амын ариун цэврийн байгууламжийн ашиглалтыг сайжруулах, аюулгүй байдлыг хангах хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэх ажлын хүрээнд 2021 оны 5-р сарын 17-21 өдрүүд болон 2021 оны 11-р сарын 02-15 өдрүүдэд 2 удаа удирдамж батлуулан хөндлөнгийн аудитын баг ажилласан бөгөөд тайлан, зөвлөмжийг албан тоотоор НЗДТГ-т хүргүүлсэн.<br>Багануур дүүргийн ЭМТ 2021 оны 3-р сарын 15-19, Орхон аймгийн Бүсийн оношлогоо эмчилгээний төв, Сэлэнгэ аймгийн Сайхан сумын Номгон тосгоны эрүүл мэндийн төв”-д 2021 оны 6-р сарын 3-12, “Дорноговь аймгийн Замын-Үүд сумын нэгдсэн эмнэлэг болон Эрдэнэ сумын эрүүл мэндийн төв”-д 2021 оны 08 дугаар сарын 2-6-ны өдрүүдэд тус тус сургалт зохион байгуулж, усны аюулгүй байдлын төлөвлөгөөний төсөл боловсруулсан. | | |
| 76 | 2.1.12. Аймаг, сумын эрүүл мэндийн байгууллага, эмнэлгүүдийн барилга байгууламж, дэд бүтцийг | 3.Өрх, сумын эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлгийн барилгыг шинэчилнэ | 2021-2024 | 9,300.0 Улсын төсөв, Гадаадын зээл, тусламж | Өрх, сумын эрүүл мэндийн төвийн барилгын ажил эхэлсэн байна. | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд өрх, сумын эрүүл мэндийн төвийн 36 шилжих барилга байгууламжийн төсөл хэвийн үргэлжилж байна. 2021 оны Төсвийн тухай хуульд тусгагдсан 31.9 тэрбум төгрөгийн 21 шинэ барилгын худалдан авах ажиллагааг зохион байгуулж, 19 | СЭЗГ-ХОХ<br><br>I-IV улирал | **100.0** |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв, 2021 он (сая төгрөг), Эх үүсвэр | 2021 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр | Хариуцах газар, хэлтэс | Үнэлгээ-ний хувь, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | сайжруулан стандарт, чанарын | | | | | барилгын гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан бөгөөд барилга угсралтын ажил эхлээд байна. | | |
| 77 | шаардлага хангасан тэгш хүртээмжтэй, чанартай үйлчилгээг үзүүлэх орчныг бүрдүүлнэ. | 4.Сум, өрхийн эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлгийн барилга байгууламж, дэд бүтцийн стандарт боловсруулж, хэрэгжүүлнэ | 2021-2024 | 970.0 Улсын төсөв | Шаардлага хангасан байгууллагын тоо 75 болсон байна. | Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 03-дугаар тушаалаар Эмнэлгийн барилгын норм, дүрмийг баталсан. 2021 онд шинээр баригдаж байгаа сум, өрхийн эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлгийн 21 барилга нь энэхүү дүрмийн дагуу баригдаж байна. Мөн шилжих 41 барилга эмнэлгийн барилгын норм, дүрмийн дагуу хянаж байна. | ЭМСЭЗБХГ- ХОХ | **90.0** |
| 78 | | 5.Эрүүл мэндийн анхан шатны байгууллагын агаарын чанарын дэд бүтцийг сайжруулна | 2021-2022 | 1,000.0 Гадаадын зээл, тусламж | 2 Өрхийн эрүүл мэндийн төвд Агаар сэлгэлтийн механик систем, 10 ӨЭМТ-д Агаарын чанарыг хянах бага оврын төхөөрөмжийг суурилуулсан; 100 өрхөд Монгол гэрийн дулаалга, халаалтын багцыг нэвтрүүлсэн; БХ аймгийн агаарын чанарын хяналтын харуулын мэдээллийг үндэсний мэдээллийн системтэй | Швейцарын хөгжлийн агентлаг, НҮБ-ын Хүүхдийн сангийн хамтарсан санхүүжилттэй Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэг, Баянхонгор аймагт хэрэгжих “Эх, хүүхдийн эрүүл мэндэд агаарын бохирдлын нөлөөг бууруулах нь” төслийн хүрээнд 2 Өрхийн эрүүл мэндийн төвд Агаар сэлгэлтийн механик систем байрлуулах, 10 ӨЭМТ-д Агаарын чанарыг хянах бага оврын төхөөрөмжийг суурилуулах, 3308.000 ам.долларын санхүүжилтийн эх үүсвэрийг баталгаажуулсан.<br>Монгол гэрийн дулаалга, халаалтын багц буюу ЧИП-ыг төсөл хэрэгжүүлэгч Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэг, 3 аймгийн орон нутгийн 12 үйлдвэрлэгч 100 ажилтантайгаар уг багцыг чанарын шаардлага хангах хэмжээнд үйлдвэрлэж эхэлсэн. Орон нутгийн | НЭМГ<br>I-IV улирал | **100.0** |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв, 2021 он (сая төгрөг), Эх үүсвэр | 2021 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр | Хариуцах газар, хэлтэс | Үнэлгээ-ний хувь, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | холбосон байна. | төсвийн санхүүжилтээр Баянхонгор аймагт Монгол гэрийн дулаалга, халаалтын багцад 150 сая, Өмнөговь аймаг 150 сая, Говь-Алтай аймаг 46.6 сая төгрөгийг шийдвэрлүүлж 100 өрхөд 115.2 сая төгрөгийг хуваарилсан. Баянхонгор аймгийн агаарын чанарын хяналтын харуулын мэдээллийг үндэсний мэдээллийн системтэй холбох ажлыг Цаг уур, орчны шинжилгээний газартай хамтран хэрэгжүүлж байна. Мөн НҮБ-ын Хүүхдийн сангаас 21 аймгийн төв, нийслэлийн 9 дүүрэг, зарим суурин газруудад гадаад орчны агаарын чанарыг хэмжих жижиг оврын 28.4 сая төгрөгийн үнэ бүхий 33 төхөөрөмжийг худалдан авч Цаг уур, орчны шинжилгээний газарт хүлээлгэн өгсөн.<br>Төслийн үр шимийг Баянзүрх дүүрэг (361.700), Баянхонгор аймгийн (40.000) нийт 400.000 гаруй хүн ам хүртээд байна. 3 аймгийн 90-100 өрх болон Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн 100 өрх, 2 цэцэрлэгт чип суурилуулсан. Баянхонгор аймгийн агаарын чанарын хяналтын харуулын мэдээллийг үндэсний мэдээллийн системтэй холбох ажлыг Цаг уур, орчны шинжилгээний газартай хамтран хэрэгжүүлж байна. | | |
| 79 | | 6.Захиалгын дагуу барилга | 2021-2024 | 46.8 Улсын төсөв | Нэг маягийн зураг, давтан хэрэглэх | Сумын 10, 15, 22 ортой Эрүүл мэндийн төв, 50 ортой Хүүхдийн эмнэлгийн | СЭЗГ-ХОХ | **100.0** |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв, 2021 он (сая төгрөг), Эх үүсвэр | 2021 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр | Хариуцах газар, хэлтэс | Үнэлгээ-ний хувь, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | байгууламжийн нэг маягийн болон давтан хэрэглэх зураг төсөл боловсруулах ажлыг зохион байгуулна | | | зураг төслийг боловсруулж батлуулсан байна. | барилга байгууламжийн нэг маягийн болон давтан хэрэглэх зураг төслийг Нийслэлийн хот байгуулалтын хөгжлийн газраар 2021 онд батлуулж, 21 аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. 30 ортой сүрьеэгийн эмнэлэг, Зоонозын өвчин судлалын төвийн барилгын нэг маягийн зураг, давтан хэрэглэх зураг төслийг боловсруулсан. | | |
| 80 | 2.1.13. Өрхийн эрүүл мэндийн төвийн статусыг тодорхой болгож, санхүүжилтийг оновчтой хэлбэрээр шийдвэрлэнэ. | 1.Өрхийн эрүүл мэндийн төвийн эрхзүйн баримт бичигт шинэчлэл хийж, өрхийн эрүүл мэндийн төвийн хувилбаруудыг турших, оновчтой хэлбэрийг сонгон нэвтрүүлнэ | 2021-2024 | - | Өрхийн эрүүл мэндийн төвийн эрхзүйн баримт бичигт шинэчлэл хийсэн байна. | “Өрхийн эрүүл мэндийн төвийн үлгэрчилсэн дүрэм”-ийг шинэчлэн боловсруулж, Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/212 дугаар тушаалаар баталсан.<br>Эрүүл мэндийн анхан шатны байгууллагад мөрдөж буй эрх зүйн зарим баримт бичгийг шинэчлэн боловсруулах ажлын хэсэг Эрүүл мэндийн сайдын 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн А/412 дугаар тушаалаар байгуулагдан ажиллаж байна. Ажлын хэсэг нь Өрхийн эрүүл мэндийн төвтэй гэрээ байгуулах, хэрэгжилтийг дүгнэх, хяналт тавих, гэрээг сунгах, дуусгавар болгох журам, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт; Өрхийн эрүүл мэндийн төвийг сонгон шалгаруулах журам; Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд үзүүлэх тусламж, үйлчилгээний багц, журмын төсөл боловсруулан холбогдох байгууллагуудаас санал авч эцэслэсэн. | ЭТҮГ<br>I-IV улирал | **90.0** |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв, 2021 он (сая төгрөг), Эх үүсвэр | 2021 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр | Хариуцах газар, хэлтэс | Үнэлгээ-ний хувь, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 81 | 2.1.13. Өрхийн эрүүл мэндийн төвийн статусыг тодорхой болгож, санхүүжилтийг оновчтой хэлбэрээр шийдвэрлэнэ. | 2.Эрүүл мэндийн анхан шатлалын тусламж, үйлчилгээний багцыг оновчтой болгож, гүйцэтгэлийн шалгуурын дагуу тусламж, үйлчилгээ, иргэнийг дагасан гүйцэтгэлийн санхүүжилтийг нэвтрүүлнэ | 2021-2024 | 250.0 Улсын төсөв (ЭМДС) | Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд нэвтрүүлж эхэлнэ. | ЭМДҮЗ-ийн 2021 оны 04 дүгээр тогтоолоор “Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээ, арга, журам”-ыг шинэчлэн батлан хэрэгжүүлж байна. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагад мөрдөж буй эрх зүйн зарим баримт бичгийг шинэчлэсний дараа 2022 онд Төсвийн тухай хуульд өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн санхүүжилттэй холбоотой заалтад нэмэлт, өөрчлөлт оруулж, анхан шатны тусламж, үйлчилгээтэй холбоотой заалтад тусламж, үйлчилгээ, иргэнийг дагасан гүйцэтгэлийн санхүүжилтийг нэвтрүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна. | ЭТҮГ, СЭЗГ-СДХ<br><br>I-IV улирал | **50.0** |
| 82 | | 3.Эрүүл мэндийн анхан шатлалын тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжид үйлчлүүлэгчийн хөндлөнгийн үнэлгээний тогтолцоо бүрдүүлэх, ил тод, нээлттэй болгоно | 2021-2024 | 500.0 Улсын төсөв (ЭМДС) | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хөндлөнгийн төрийн бус байгууллагаар үнэлгээ хийгдсэн байна. | Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/578 дугаар тушаалаар “Эрүүл мэндийн салбараар үйлчлүүлж буй хэрэглэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээ хийх журам” батлагдсан. Говьсүмбэр аймгийн эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний өнөөгийн нөхцөл байдал, сэтгэл ханамжийн үнэлгээг хөндлөнгийн байгууллага АШУҮИС гүйцэтгэсэн. | ЭТҮГ<br><br>I-IV улирал | **100.0** |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв, 2021 он (сая төгрөг), Эх үүсвэр | 2021 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр | Хариуцах газар, хэлтэс | Үнэлгээ-ний хувь, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 83 | | 4.Өрхийн эрүүл мэндийн төвийн төсвийг тооцох аргачлал, санхүүжүүлэх, хяналт тавих журмыг шинэчлэнэ | 2021-2024 | - | Журам шинэчлэн батлагдсан байна. | Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 04 дүгээр тогтоолоор “Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн төсвийг тооцох, ЭМДС-аас санхүүжүүлэх журам”-ыг баталсан. | СЭЗГ-СДХ<br><br>I-IV улирал | **100.0** |
| 84 | 2.1.14. Нүхэн жорлонтой эмнэлгийг үе шаттайгаар орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгоно. | 1.Эрүүл мэндийн анхан шатны байгууллагуудыг сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болгоно | 2021-2024 | 5,000.0 Улсын төсөв, Гадаадын зээл, тусламж | 60 сумын эрүүл мэндийн төвийг үе шаттайгаар орчин үеийн нүхэн жорлон, ариун цэврийн байгууламжтай болгосон байна. | БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага КОЙКА, НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран Баянхонгор, Говь-Алтай, Завхан аймагт хэрэгжүүлж буй “Орон нутгийн иргэдэд түшиглэсэн, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн үйлчилгээ” төслийн хүрээнд 3 аймгийн 11 сум, НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүжилтээр 3 аймгийн 4 сум, нийт 3 аймгийн 15 сумын Эрүүл мэндийн төвд нүхэн жорлон ба сайжруулсан ариун цэврийн байгууламжийг нэвтрүүлэх 423.0 сая төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг баталгаажуулсан. Баянхонгор аймгийн Заг сумын Эрүүл мэндийн төвийн ариун цэврийн өрөөний өргөтгөл, Говь-Алтай аймгийн Бугат сумын халдвартын эмнэлэг, Хөхморьт сумын ЭМТ-ийн ариун цэврийн байгууламжийн сайжруулалт, | НЭМГ<br><br>I-IV улирал | **30.0** |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв, 2021 он (сая төгрөг), Эх үүсвэр | 2021 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр | Хариуцах газар, хэлтэс | Үнэлгээ-ний хувь, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Завхан аймагт Цагаанчулуут сумын эмнэлэгт зөөврийн контейнер ашигласан ариун цэврийн байгууламж байгуулах ажил хийгдсэн. | | |
| 85 | 2.5.8. Гэр бүл, хүүхэд залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг дээдэлсэн, нийгмийн бүх бүлгийн оролцоог хангасан хүний хөгжлийн цогц бодлого хэрэгжүүлнэ. | 5.Эрүүл, бүтээлч амьдрал, идэвхтэй, насжилтыг дэмжсэн, ахмад настанд ээлтэй, тэгш хүртээмжтэй урт хугацааны тусламж, үйлчилгээний тогтолцоог нэвтрүүлнэ | 2021-2024 | 240.0 Улсын төсөв | Төлөвлөгөө батлагдаж, хэрэгжилт 20-иос доошгүй хувьд хүрсэн байна. | Ахмад настны эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлийг Эрүүл мэндийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/792 дугаар тушаалаар батлуулсан. Тус дэд зөвлөлийн хурлаар "Эрүүл, бүтээлч амьдрал, идэвхтэй, насжилтыг дэмжсэн, ахмад настанд ээлтэй, тэгш хүртээмжтэй урт хугацааны тусламж, үйлчилгээний тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр 2021-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"-г хэлэлцүүлэхээр бэлдэж байна.<br>Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/749 дүгээр тушаалаар "Сэргээн засах тусламж, үйлчилгээг хөгжүүлэх 2021-2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөө"-г баталсан. | ЭТҮГ<br><br>(ХНХЯ) | **30.0** |
| 86 | | 7.Гэр бүл, хүүхэд, залуучууд, ахмад настны хөгжлийн цогц төвүүдийг байгуулж, хүн амын бүлгүүдийн онцлогт нийцсэн хөгжлийн үйлчилгээ үзүүлэх орчныг бүрдүүлнэ. | 2021-2024 | -<br>Улсын төсөв | Аймаг, дүүргийн хүүхдийн ордон, төвүүдийг түшиглэн Гэр бүл, хүүхэд, залуучууд, ахмад настны хөгжлийн цогц төвийг байгуулсан байна. | Гэр бүл, хүүхэд, залуучууд, ахмад настны хөгжлийн цогц төвүүдийг байгуулж, хүн амын бүлгүүдийн онцлогт нийцсэн хөгжлийн үйлчилгээ үзүүлэх орчныг бүрдүүлэх чиглэлээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас хамтран ажиллах чиглэл 2021 онд ирээгүй байна. Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болно. | НЭМГ, ЭТҮГ<br><br>(ХНХЯ) | **-** |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв, 2021 он (сая төгрөг), Эх үүсвэр | 2021 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр | Хариуцах газар, хэлтэс | Үнэлгээ-ний хувь, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО** | | | | | | | | |
| 87 | 4.2.5.Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн алба хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана. | 3.Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэмд өөрчлөлт оруулна. Төрийн албаны үнэт зүйл, зарчим, манлайллыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх талаар сургалт, сурталчилгааны хөтөлбөрийг батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллана (Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийг хэрэгжүүлж байна). | 2021-2024 | - | Дүрэмд өөрчлөлт оруулах саналыг холбогдох байгууллагад хүргүүлнэ. Төрийн албаны үнэт зүйл, зарчим, манлайллыг хангах талаарх сургалт, сурталчилгааны хөтөлбөрийг батлуулж, хэрэгжилтийг эхлүүлнэ. | Яамны албан хаагчдаас нууц санал хураалт авч, дийлэнхи санал авсан 5 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй Ёс зүйн зөвлөлийг Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны А/86 дугаар тушаалаар байгуулсан. ЭМЯ-ны Ёс зөвлөл 2021 онд нийт 4 удаа хуралдаж зөвлөлийн даргыг сонгож, албан бичиг, тогтоолын загварыг гарган хэвлүүлж, үйл ажиллагааны төлөвлөгөө баталж, төрийн албан хаагчаас ирүүлсэн өргөдлийг тухай бүр хэлэлцэн ажилласан.<br>Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилгын тухай хуулийн төсөлд Хяналтын хороо, Ёс зүйн салбар хороо, хэсгийн хороодоос санал авч хурлаар хэлэлцүүлэн саналыг хүргүүлсэн. | ТЗУГ<br>I-IV улирал | **70.0** |

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв, 2021 он (сая төгрөг), Эх үүсвэр | 2021 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр | Хариуцах газар, хэлтэс | Үнэлгээ-ний хувь, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **ТАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | | | | | |
| 88 | 5.1.4.Гэр хороолол болон аялал жуулчлалын бүсэд "Эко жорлон" арга хэмжээг хэрэгжүүлж, хөрсний бохирдлыг бууруулна. | 2.Аялал жуулчлалын бааз болон худалдаа, үйлчилгээний байгууллагуудын ариун цэврийн байгууламжийг стандартын шаардлага хангуулна | 2021-2024 | 80.0 Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, /Хувийн хэвшил/ Гадаадын зээл, тусламж | Аялал жуулчлалын бааз болон худалдаа, үйлчилгээний бусад байгууллагуудын жорлонг үе шаттайгаар стандартын шаардлагад нийцүүлсэн байна. | Улсын хэмжээнд нүхэн жорлонтой 238 сумын эрүүл мэндийн төвийн судалгааг гаргасан. 4 эрэгтэй, 4 эмэгтэй жорлон, усанд орох эрэгтэй, эмэгтэй шүршүүр бүхий 1 байгууламжийг цэвэр, бохир усны шугам сүлжээнд холбоход 1 сумын эрүүл мэндийн төвд 70.0-90.0 сая төгрөг шаардлагатай гэсэн тооцоо гарсан. Эрүүл мэндийн төвийн жорлонг стандартын шаардлагад нийцүүлэх зураг төсөв хийгдсэн. | НЭМГ (БОАЖЯ) | **30.0** |
| **ҮНЭЛГЭЭНИЙ ХУВЬ** | | | | | | **76.7** | | |

Эрүүл мэндийн яам
2022 оны 01 дүгээр сар